

**ИННОВАЦ, ЦАХИМ БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**  
**2024 оны 12 дугаар сарын 18-ны өдөр, Лхагва гараг**

**Хуралдааны тэмдэглэлийн агуулга**

**Хуралдааны товч тэмдэглэл:** 1-3

**Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:** 4-43

---

|   |       |
|---|-------|
| 1.Шинжлэх ухаан, технологи, инновацыг хөгжүүлэх талаарх Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын мэдээллийг сонсох | 4-22  |
| 2.Улсын Их Хурлын 2024 оны 05 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаарх Харилцаа холбооны зохицуулах хорооны даргын мэдээллийг сонсох             | 22-43 |

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы  
Инновац, цахим бодлогын байнгын хорооны  
12 дугаар сарын 18-ны өдөр /Лхагва гараг/-ийн  
хуралдааны товч тэмдэглэл**

Инновац, цахим бодлогын байнгын хорооны дарга Ж.Золжаргал ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 11 гишүүнээс 6 гишүүн хүрэлцэн ирж, 54.5 хувийн ирцтэйгээр хуралдаан 11 цаг 34 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: Э.Батшугар, А.Ганбаатар, Ц.Мөнхбат, Б.Пунсалмаа.

**Нэг.Шинжлэх ухаан, технологи, инновацыг хөгжүүлэх талаарх  
Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын  
мэдээллийг сонсох**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Эдийг засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, мөн яамны Шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлогын газрын дарга Д.Баттогтох, Технологи, инновацын шилжилт, эрчимт хөгжлийн судалгааны хэлтсийн дарга Б.Урьболд, Шинжлэх ухааны бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга Б.Мөнгөнсүх, Үндэсний шинжлэх ухаан, технологийн сангийн Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга Л.Энхтунгалаг, Шинжлэх ухааны паркийн захиргааны гүйцэтгэх захирал Б.Амарсанаа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Инновац, цахим бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Бат-Эрдэнэ, референт Р.Дэлгэрмаа нар байлцав.

Шинжлэх ухаан, технологи, инновацыг хөгжүүлэх талаарх мэдээллийг Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, мөн яамны Шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлогын газрын дарга Д.Баттогтох нар тус тус танилцуулав.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрэм, С.Цэнгүүн, Ч.Анар, Ж.Галбадрах нарын тавьсан асуултад Байнгын хорооны дарга Ж.Золжаргал, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, мөн яамны Шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлогын газрын дарга Д.Баттогтох нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ч.Анар, Ж.Золжаргал нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд Шинжлэх ухаан, технологи, инновацыг хөгжүүлэх талаарх Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, мөн яамны Шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлогын газрын дарга Д.Баттогтох нарын мэдээллийг сонсов.

Уг асуудлыг 12 цаг 41 минутад хэлэлцэж дуусав.

**Хоёр.Улсын Их Хурлын 2024 оны 05 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаарх Харилцаа холбооны зохицуулах хорооны даргын мэдээллийг сонсох**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч П.Алтан-Од, мөн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ш.Батзаяат, мөн газрын ахлах шинжээч Б.Эрдэнэ, Харилцаа холбооны хэрэгжилтийг зохицуулах газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Баясгалан, Сансрын холбооны хэлтсийн шинжээч С.Онончимэг, Харилцаа холбооны хэрэгжилтийг зохицуулах газрын мэргэжилтэн Ш.Самданжамц, Харилцаа холбооны зохицуулах хорооны дарга Г.Чинзориг, мөн хорооны Ажлын албаны дарга А.Лувсан-Очир, Зохицуулалтын газрын дарга Т.Батболд, Радио давтамжийн зохицуулалт, хяналтын газрын дарга З.Амгалан, Хуулийн хэлтсийн дарга Т.Ууганбат, “Мэдээлэл холбооны операторуудын ассоциаци”-ийн гүйцэтгэх захирал У.Тамир, “Ондо” ХХК-ийн гүйцэтгэх захирал Б.Мандуул, мөн компанийн Хууль хариуцсан захирал Ц.Одмаа, “Жи-Мобайл” ХХК-ийн Техник хариуцсан захирал А.Энх-Амгалан, “Мобиком Корпораци” ХХК-ийн Технологийн газрын захирал Б.Ганзориг, мөн компанийн Бодлого, зохицуулалтын албаны дарга Ч.Буянтогтох, “Скайтел” ХХК-ийн Технологийн газрын захирал Я.Батжаргал, “Юнител” ХХК-ийн Техник хариуцсан дэд захирал Г.Бат-Эрдэнэ, мөн компанийн Эрсдэлийн удирдлага, хууль комплаенс хариуцсан дэд захирал Л.Пагамсүрэн, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын зөвлөх М.Тулгат нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Инновац, цахим бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Бат-Эрдэнэ, референт Р.Дэлгэрмаа нар байлцав.

Улсын Их Хурлын 2024 оны 05 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаарх мэдээллийг Харилцаа холбооны зохицуулах хорооны дарга Г.Чинзориг, мөн хорооны Ажлын албаны дарга А.Лувсан-Очир, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч П.Алтан-Од, “Мобиком Корпораци” ХХК-ийн Бодлого, зохицуулалтын албаны дарга Ч.Буянтогтох, “Юнител” ХХК-ийн Техник хариуцсан дэд захирал Г.Бат-Эрдэнэ, “Скайтел” ХХК-ийн Технологийн газрын захирал Я.Батжаргал, “Ондо” ХХК-ийн гүйцэтгэх захирал Б.Мандуул, “Жи-Мобайл” ХХК-ийн Техник хариуцсан захирал А.Энх-Амгалан, “Мэдээлэл холбооны операторуудын ассоциаци”-ийн гүйцэтгэх захирал У.Тамир нар тус тус танилцуулав.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрэм, С.Цэнгүүн, Ж.Золжаргал нарын тавьсан асуултад Харилцаа холбооны зохицуулах хорооны Ажлын албаны дарга А.Лувсан-Очир, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч П.Алтан-Од, мөн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ш.Батзаяат, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын зөвлөх М.Тулгат, “Мэдээлэл холбооны операторуудын ассоциаци”-ийн гүйцэтгэх захирал У.Тамир, “Юнител” ХХК-ийн Эрсдэлийн удирдлага, хууль комплаенс хариуцсан дэд захирал Л.Пагамсүрэн нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргал үг хэлэв.

Улсын Их Хурлын 2024 оны 05 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаарх Харилцаа холбооны зохицуулах хорооны дарга Г.Чинзориг, мөн хорооны Ажлын албаны дарга А.Лувсан-Очир, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч П.Алтан-Од, “Мобиком Корпораци” ХХК-ийн Бодлого, зохицуулалтын албаны дарга Ч.Буянтогтох, “Юнител” ХХК-ийн Техник хариуцсан дэд захирал Г.Бат-Эрдэнэ, “Скайтел” ХХК-ийн Технологийн газрын захирал Я.Батжаргал, “Ондо” ХХК-ийн гүйцэтгэх захирал Б.Мандуул, “Жи-Мобайл” ХХК-ийн Техник хариуцсан захирал А.Энх-Амгалан, “Мэдээлэл холбооны операторуудын ассоциаци”-ийн гүйцэтгэх захирал У.Тамир нарын мэдээллийг сонсов.

*Уг асуудлыг 14 цаг 03 минутад хэлэлцэж дуусав.*

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 2 цаг 29 минут үргэлжилж, 11 гишүүнээс 7 гишүүн хүрэлцэн ирж, 63.6 хувийн ирцтэйгээр 14 цаг 03 минутад өндөрлөв.*

Тэмдэглэлтэй танилцсан:  
ИННОВАЦ, ЦАХИМ БОДЛОГЫН  
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Ж.ЗОЛЖАРГАЛ

Тэмдэглэл хөтөлсөн:  
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ  
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 12 дугаар сарын 18-ны өдөр,  
Лхагва гараг  
Төрийн ордон “Их эзэн Чингис хаан” танхим  
11 цаг 34 минут.

### ИННОВАЦ, ЦАХИМ БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

**Ж.Золжаргал:** Байнгын хорооны гишүүдийн энэ өдрийн мэндийг айлтгая. Тэгээд хүрэлцэн ирсэн албан тушаалтнууддаа өдрийн мэнд хүргэе. Байнгын хорооны гишүүдийн ирц 63,6 хувь хүрсэн учраас Инновац, цахим бодлогын байнгын хорооны 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье. Өнөөдрийн хурлаар хэлэлцэх асуудлаа ярихаас өмнө ирцээ танилцуулах ёстой. Чинбаатарын Анар гишүүн ирсэн байна, Жанчивын Галбадрах гишүүн, Жаргалсайханы Золжаргал гишүүн, Тогтмолын Мөнхсайхан гишүүн, Чинбатын Номин гишүүн, Чинбатын Ундром гишүүн, Саруулсайханы Цэнгүүн гишүүн. Ингээд 63,6 хувийн ирцтэйгээр хуралдаанаа эхлүүлж байна.

Хэлэлцэх асуудал 2 асуудал байгаа. 1 дүгээрт Шинжлэх ухаан, технологи, инновацыг хөгжүүлэх талаар Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын мэдээллийг сонсох. 2 дугаарт нь Улсын Их Хурлын 2024 оны 5 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаарх Харилцаа холбооны зохицуулах хорооны даргын мэдээллийг сонсох гээд. Тэгээд нэг нь бол шинжлэх ухаан технологийн болоод инновацын бодлогыг хэрэгжүүлэхэд тулгамдаж байгаа асуудлууд, эрх зүйн зохицуулалт ямар байна вэ? Нөгөөх нь болохоор нөгөө дугаартаа шилжих асуудалтай холбоотойгоор дотоодын роумингийн үйлчилгээг нэвтрүүлэх Их Хурлын тогтоолын нэг заалт гарсан. Тэгээд тэрний хэрэгжилт хангалтгүй байгаа учраас ямар асуудал байна вэ гээд ийм 2 сэдвээр ярилцахаар төлөвлөсөн байгаа. Хэлэлцэх асуудал дээр нэмэлт саналтай гишүүд байвал саналаа хэлнэ үү? Санал байхгүй байна.

#### **Нэг.Шинжлэх ухаан, технологи, инновацыг хөгжүүлэх талаарх Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын мэдээллийг сонсох**

Хэлэлцэх асуудал 1.Шинжлэх ухаан, технологи, инновацыг хөгжүүлэх талаар танилцуулгыг Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засгийн хөгжлийн сайд Засгийн газрын хуралдаантай байгаа учраас ТНБД Батхүү хийхээр хүрэлцэн ирсэн байгаа. Хүмүүсээ танилцуулах уу? Хэлэлцэх асуудалтай холбоотой албан тушаалтнуудыг танилцуулъя. Эдийн засаг, хөгжлийн яамны Шинжлэх ухаан технологийн нэгдсэн бодлогын газрын дарга Баттогтох, Эдийн засаг, хөгжлийн яамны Технологи, инновацын шилжилт эрчимт хөгжлийн судалгааны хэлтсийн дарга Урьболд, Эдийн засаг, хөгжлийн яамны Шинжлэх ухааны бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга Мөнгөнсүх, Мөнгөнсүх дарга, Үндэсний шинжлэх ухаан, технологийн сангийн Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга Энхтунгалаг, Шинжлэх ухааны паркийн захиргааны гүйцэтгэх захирал Амарсанаа ийм бүрэлдэхүүнтэй албан тушаалтнууд ирсэн байна. Батхүү даргыг танилцуулгаа эхлүүлнэ үү гэж хүсье. 3 номерын микрофон нээж өгнө үү.

**И.Батхүү:** Эрхэм Улсын Их Хурлын гишүүн, Инновац, цахим бодлогын байнгын хорооны дарга, Байнгын хорооны гишүүд ээ,

Шинжлэх ухаан, технологи, инновацын салбарын өнөөгийн байдал цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын хийх танилцуулга мэдээллийг хүргэе. 1 дүгээрт Монгол Улсын шинжлэх ухаан, технологи, инновацын салбарын өнөөгийн нөхцөл байдлыг танилцуулъя. Монгол Улсын шинжлэх ухаан, технологи, инновацын салбарт Шинжлэх ухаан технологийн тухай хууль, Инновацын тухай хууль, Технологи дамжуулах тухай хууль, Патентын тухай хууль, Шинжлэх ухаан, технологийн болон инновацын үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл, ШУТС-гаас тэтгэлэг олгох, сангийн хөрөнгийг зарцуулах түүнд хяналт тавих журам, Эрдэм шинжилгээний шилдэг өгүүлэл нийтлүүлсэн судлаачийг урамшуулах журам, ЭША-ыг аттестатчилах журам, Үндэсний инновацын шагнал олгох журам зэрэг 20 гаруй хууль тогтоомж, дүрэм, журам бүхий хууль, эрх зүйн актууд мөрдөгдөж байна.

Үүнээс онцлон дурдвал 2024 онд Монгол Улсын ЗГ-аас Шинжлэх ухаан технологийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг Улсын Их Хуралд өргөн барьж батлуулсан. Тус хууль батлагдсанаар Монгол Улсын Үндсэн хуулийн 38 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2-т заасан шинжлэх ухаан технологийн нэгдсэн бодлогыг боловсруулан Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, гарсан шийдвэрийг хэрэгжүүлж байх ЗГ-ын бүрэн эрхийг хангах урт болон дунд хугацааны бодлогын баримт бичигт шинжлэх ухаан, технологи, инновацыг хөгжүүлэх чиглэлээр тусгагдсан зорилтуудыг үр дүнтэй хэрэгжүүлэхэд чиглэсэн эрх зүйн чухал түлхэц болсон.

Тус хуулиар шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагаанд оролцогчдын эрх, үүргийн хуваарилалтыг оновчтой тогтоож, удирдлага, бүтэц зохион байгуулалт, оролцооны хүрээг шинэчлэх замаар шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэх тогтолцоог системтэйгээр бүрдүүлж, нийгэм, эдийн засаг, хүний амьдралын чанарын үзүүлэлтийг дээшлүүлэхэд шинжлэх ухаан технологийг чиглүүлсэн. Түүнчлэн шинжлэх ухаан, технологи, инновацын чиглэлээр төр, хувийн хэвшлийн түншлэл нэмэгдэж, салбар дундын болон салбарт дамнасан хамтын ажиллагаа өргөжиж, шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагааны санхүүжилтийн тогтолцоо оновчтой, олон эх үүсвэртэй болгон ил тод байдал хангагдаж, санхүүжилт болон үр дүнг уялдуулан хяналтыг сайжруулах боломж бүрдсэн гэж үзэж байна.

Монгол Улсын шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагааны тогтолцоо нь ЗГ, Шинжлэх ухаан, технологи, инновацын үндэсний хороо, Шинжлэх ухаан технологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, яамдын шинжлэх ухаан, технологи, инновацын салбар зөвлөл, аймаг, нийслэлийн шинжлэх ухаан, технологи, инновацын дэд зөвлөл, ШУА, Үндэсний шинжлэх ухаан, технологийн сан, төрийн болон хувийн эрдэм шинжилгээний байгууллага, шинжлэх ухааны паркийн захиргаа хамтын оффис болон технологи дамжуулах төвүүдээс бүрдэж байна. Шинжлэх ухааны салбарт 2024 оны 10 дугаар сарын байдлаар нийт 66 эрдэм шинжилгээний байгууллага, үүнд хүрээлэн, төв болон эрдэм шинжилгээний байгууллагын зэрэглэлд хамаарах дээд боловсролын байгууллагууд тогтмол үйл ажиллагаа эрхэлж байна. Тухайлбал, яам, агентлагийн харьяа 17, ШУА-ийн харьяа 16, эрдэм шинжилгээний байгууллагын зэрэглэлд хамаарах дээд боловсролын 20, их сургуулийн харьяа 10, хувийн хэвшлийн ААН-ийн дэргэдэх 3 хүрээлэн төвүүд тус тус үйл ажиллагаа явуулж байна.

Шинжлэх ухаан, технологийн салбарыг хүний нөөцийн талаар танилцуулахад ЗГ-ын 2023 оны төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай 241 дүгээр тогтоолоор салбарын албан хаагчдын цалингийн доод хэмжээг 1,1 сая төгрөг байхаар буюу 41,5 хувиар нэмэгдүүлсэн. Түүнчлэн 2024 оны ЗГ-аас нийт төрийн албан хаагчдын цалинг 10 хувиар нэмэгдүүлсэн бөгөөд шинжлэх ухааны салбарын цалингийн системд өөрчлөлт оруулж, ТҮШУ ангиллын шатлалыг байхгүй болгож, ангилал тус бүрийн цалингийн доод хэмжээг өмнөх сүлжээний 5 дугаар шатлалын түвшинд тогтоож өгснөөр албан хаагчдын цалин нэмэгдэн ажлын үр дүнгээрээ нэмэгдэл авах боломжтой болсон.

Шинжлэх ухаан технологи, инновацын салбарын санхүүжилтийн талаар танилцуулахад шинжлэх ухааны салбарын 2023 оны санхүүжилтэд 49,3 тэрбум төгрөг зарцуулсны 78 хувь буюу 38,9 тэрбум төгрөг нь урсгал зардал, 22 хувь буюу 10,4 тэрбум төгрөг нь эрдэм шинжилгээний ажлын зардал бөгөөд энэ нь ДНБ-ий 0,11 хувийг эзэлж байна. Нийт зардлын дийлэнх хувь нь салбарын ажиллагчдын цалин хөлсний нэмэгдэл, төрийн албан хаагчдад тэтгэвэрт гарах нэг удаагийн тэтгэмжтэй холбоотой зардал эзэлж байна. Харин эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын санхүүжилт сүүлийн 3 жилд нэмэгдээгүй бөгөөд 2024 онд 12,4 тэрбум төгрөг хэвээр байна. Дээрх зардалд инновацын чиглэлээр жилд дунджаар 1-ээс 1,5 тэрбум төгрөг тусгагддаг бөгөөд уг санхүүжилтийг шинэ мэдлэг, патентыг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэн эдийн засгийн эргэлтэд оруулах, бүтээгдэхүүн, үйлчилгээ болгон хэрэглээнд нэвтрүүлэх, инновацын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, инновацын тэргүүлэх чиглэлд хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх, давтан сургах, гадаад, дотоодын байгууллага, орон нутагтаа хамтын ажиллагаа түншлэлийг өргөжүүлэхэд зарцуулж ирсэн.

Шинжлэх ухаан технологийн салбарт хийгдэж байгаа дэд бүтэц, хөрөнгө оруулалтын талаар танилцуулахад Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан Алсын хараа 2050 урт хугацааны хөгжлийн бодлогод 2030 он гэхэд шинжлэх ухаан, технологи, инновацын тэргүүлэх чиглэлийг хөгжүүлэх дэд бүтцийг өргөжүүлж, мэдлэгийн эдийн засгийг эргэлтэд оруулах тогтолцоотой болсон байна. Мөн 2.4 дэх зорилтын 2.4.9-д үндэсний инновацын тогтолцоог хөгжүүлэх шаардлагатай шинжлэх ухааны парк, инновацын татваргүй бүсийг хамтын оффист түшиглэн байгуулна. Мөн Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан Монгол Улсын ЗГ-ын 2024-өөс 28 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.3.7.9 дэх зорилтод шинжлэх ухааны хүрээлэнгүүдийн нэгдсэн цогцолборыг ашиглалтад оруулна гэж тус тус заасан.

Энэхүү зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд эрдэм шинжилгээний хүрээлэнгүүдийн нэгдсэн цогцолборын бүтээн байгуулалтын ажлыг БЗД-ийн нутаг дэвсгэрт эхлүүлсэн. Нийт 4,8 га 74300м<sup>2</sup> ашиглалтын талбай бүхий олон улсын стандартад нийцсэн лаборатори, оффис, музей, спорт заал бүхий шинжлэх ухаан, инновац, технологи, танин мэдэхүйн иж бүрэн цогцолбор бий болох бөгөөд ШУА-ийн харьяа хүрээлэнгүүд, эрдэм шинжилгээний байгууллагуудын 3300 орчим эрдэмтэн, судлаач, албан хаагчид ажиллах орчин бүрдэх юм. Тус цогцолборын барилгын ажлыг 2020 оны 10 дугаар сард эхлүүлж, 3 тэрбум төгрөг, 2021 онд 21 тэрбум төгрөг, 2022 онд 18 тэрбум төгрөг, 2023 онд 27 тэрбум, 2024 оны 10 дугаар сарын байдлаар 11 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. 2024 оны 3 дугаар улирлын байдлаар цогцолборын нийт гүйцэтгэл 50 хувьтай үргэлжилж байна.

Шинжлэх ухааны паркийн хувьд Эдийн засаг, хөгжлийн яамнаас паркийг байгуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх, паркийн байршил, удирдлага, зохион

байгуулалт, тэдгээрт явуулах үйл ажиллагаа, хүний нөөц, хөрөнгө оруулалт, санхүүжилтийн асуудлыг оновчтой тогтоох чиглэлээр судалгаа хийж, шинжлэх ухааны паркийн техник, эдийн засгийн үзүүлэлтийг боловсруулах урьдчилсан судалгааны ажлыг тодорхой үе шаттай хийж хэрэгжүүлж байна. Түүнчлэн шинжлэх ухааны паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн үзэл баримтлалыг шинэчлэн боловсруулж, ХЗДХЯ-тай хамтран батлуулахаар ажиллаж байна.

Тус хууль батлагдсанаар шинжлэх ухааны парк байгуулах, тэдгээрийн үйл ажиллагаа, дэд бүтэц, удирдлага, зохион байгуулалтын тааламжтай нөхцөл бүрдэхийн зэрэгцээ үйлдвэржүүлэлт болон технологийн дэвшил, инновацын хөгжлийг цогцоор нь хөгжүүлэх, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдыг татах, оролцогч талуудын хамтын эзэмшилд суурилсан бизнесийн таатай орчин бэхжиж, хөрөнгө оруулалт эдийн засгийн тэлэлт бий болох эрх зүйн тогтвортой орчин бүрдэнэ. Урьдчилсан байдлаар 2020 онд Шинжлэх ухааны паркийн байршлын тогтоох судалгааг хийлгэж, 2020 оны 5 дугаар сард Нийслэлийн Хот байгуулалт, хөгжлийн газрын Ерөнхий архитекторын ажлын албанд Шинжлэх ухааны паркийн холбогдох мэдээллүүдийг хүргүүлсний үр дүнд Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Алсын хараа 2050-ийн зорилт болон Улаанбаатар хотын олон улсын нисэх онгоцны шинэ буудлыг даган хөгжих шинэ Зуунмод хотын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд тусгуулсан.

Шинжлэх ухаан технологийн төслүүдийн талаар эдийн засгийн үр өгөөж, судалгаа, хөгжүүлэлтийн ажил, үр дүнгийн талаар танилцуулахад сүүлийн жилүүдэд Монголын эрдэмтдийн бүтээл дэлхийн түвшинд үнэлэгдэж, хэвлүүлсэн бүтээлийн тоо жилээс жилд тогтмол өссөөр байна. Тухайлбал сүүлийн 20 жилийн дотор Монгол эрдэмтдийн гадаадад хэвлүүлсэн бүтээлийн тоо 10 дахин өсөж, жилийн дундаж өсөлт нь дунджаар 9 хувьтай байна. Монгол Улсаас Scopus-т бүртгэлтэй мэргэжлийн сэтгүүлүүдэд хэвлүүлж буй бүтээлийн тоо 2024 оны 9 дүгээр сарын байдлаар 10201-д хүрч, нийт 172853 удаа эшлэл аваад байна. Энэ үзүүлэлтээр Монгол Улс Азийн эхний 21 дэх улсын эгнээнд орсон байна. Жилд авагдаж буй эшлэлийн тоо 2008 онд 2032 байсан бол, 2020 онд 22 онд 20614-д хүрч 10 дахин нэмэгдсэн байна. Түүнчлэн АНУ-ын web of science группийн мэдээллийн санд манай улсаас анхны эрдэм шинжилгээний бүтээл 1967 онд бүртгэгдэж байсан бол 2024 оны 10 дугаар сарын байдлаар нийт 7731 бүтээл эшлэл 108572-т хүрч h index 118 болсон үзүүлэлттэй байна.

Монгол Улсын ЗГ-ын 2022 оны 409 дүгээр тогтоолоор төрийн өмчит эрдэм шинжилгээний хүрээлэн төвийн судалгааны үндсэн чиглэлийг тогтоож, санхүүжүүлэх журам батлагдсан. Энэхүү журам баталснаар шинжлэх ухаан технологийн салбарын үйл ажиллагаанд үр дүнд суурилсан өрсөлдөөнт болон тогтмол санхүүжилтийн тогтолцоо бүрэн хэрэгжиж эхэлсэн. Эрдэм шинжилгээний хүрээлэн төвүүдийн судалгааны үндсэн чиглэлд тогтмол санхүүжилт олгосноор тэдгээр байгууллагын биет болон биет бусын нөөцийн ашиглалт, засаглал, менежмент сайжирч, цаашлаад судалгааны ажлыг улсын хөгжлийн бодлоготой уялдуулах, салбар дундын болон салбар дамнасан судалгааг эрхлэх, судалгаа хөгжүүлэлтийн ажлын үр дүн дээшлэх боломж бүрдсэн.

ЗГ-ын 2020 оны 95 дугаар тогтоолоор баталсан 2020-2025 онд баримтлах инновацын үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлд Монгол Улсын шинжлэх ухаан, технологи, инновацын хөгжлийн суурийг бэхжүүлэх, эдийн засгийн бүтээмжийг нэмэгдүүлэх зорилгоор 6 тэргүүлэх чиглэл, 11 тэргүүлэх технологийн чиглэлийг тодорхойлсон. Түүнчлэн 2023 оны 249 дүгээр тогтоолоор Монгол Улсын шинжлэх



ухаан, технологийг хөгжүүлэх тэргүүлэх чиглэл, цөм технологийн жагсаалтыг 2023 оноос 2026 онд гэсэн байдлаар баталсан. Монгол Улсын байгаль, нийгэм, аж үйлдвэрийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, эдийн засгийн тэргүүлэх чиглэлтэй нягт уялдуулах зарчмаар 6 тэргүүлэх чиглэл, 18 цөм технологийг тодорхойлон баталсан байна. Шинжлэх ухаан, технологи болон инновацын тэргүүлэх чиглэл цөм технологид хөрөнгийн нөөцийг төвлөрүүлэх замаар судалгаа, хөгжүүлэлтийн ажлыг эрчимжүүлж, улмаар үр дүнг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэн аж үйлдвэрийн өрсөлдөх чадвар дээшилнэ гэж үзэж байна.

Үндэсний инновацын үр ашигтай тогтолцоог бүрдүүлэх, инновацын бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэх, эдийн засгийн эргэлтэд оруулах зорилгоор Технологи дамжуулах төв болон хамтын оффист гишүүнчлэлээр бүртгүүлсэн гарааны компани болон программ хангамжийн үйлдвэрлэл, хөгжүүлэлтийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжид татварын хөнгөлөлт, гарааны санхүүгийн дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн бодлого шийдвэр бүхий эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлэх зорилгоор гарааны компани болон программ хангамжийн үйлдвэрлэл хөгжүүлэлтийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ААН-д дэмжлэг үзүүлэх журмын 2023 онд боловсруулж, Засгийн газраар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Монгол Улсын хэмжээнд инновацын соёлыг түгээх бүс, орон нутаг нийслэлд тулгамдаж буй асуудлыг шинэ санаа, инновац ашиглан шийдэх санаачилгыг дэмжих MON-X хөтөлбөрийг 22 оноос санаачлан жил бүр хэрэгжүүлж ирлээ. Хөтөлбөрийн хүрээнд нийт 2500 гаруй хүнд инновацын талаар сургалт зохион байгуулж, шилдгээр шалгарсан нийт 18 төсөлд тус бүр 20 сая төгрөгийн grant олгосон байна. Мөн түүнчлэн Монголын инновацын долоо хоног арга хэмжээг 2015 оноос жил бүр тогтмол зохион байгуулж байна. Тус арга хэмжээний хүрээнд инновацын форум, үзэсгэлэн, семинар, судалгаа, хөгжүүлэлтэд суурилсан төслийн Хакатон оюутнуудын цахим бизнесийн загварын тэмцээн, их сургуулиудын инновац, шинэ бүтээлүүдийн танилцуулга, шинжлэх ухааны боловсрол, залуу судлаачдын эрдэм шинжилгээний бага хурал, технологийн экспог хувийн хэвшил, эрдэм шинжилгээний их сургууль болон олон улсын байгууллагуудтай хамтран амжилттай зохион байгууллаа. Сүүлийн 2 жилд тус арга хэмжээний хүрээнд нийт 600 гаруй шинэ бүтээгдэхүүн, технологи танилцуулагдаж, 89650 оролцогч танхимаар, 600 мянга гаруй оролцогч цахимаар тус тус хамрагдсан байна.

Цаашид арга хэрэгжүүлэх арга хэмжээний тухай танилцуулахад Монгол Улсын ЗГ-ын 2024-өөс 28 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулан Улсын Их Хуралд өргөн барьж батлуулсан. Энэхүү үйл ажиллагааны хөтөлбөрт шинжлэх ухаан, технологийн арга хэмжээний зардлыг Дотоодын нийт бүтээгдэхүүний 1 хувьд хүргэж, шинжлэх ухаан, инновац, технологид суурилсан мэдлэгийн эдийн засгийн суурийг бэхжүүлнэ гэж зорилтыг тусган батлуулсан. Тус зорилтын хүрээнд Эдийн засаг, хөгжлийн яамнаас дараах арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.

Үүнд, 1 дүгээрт 2024 онд шинээр батлуулсан Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн хэрэгжилтийг бүрэн хангах, 2 дугаарт судалгаа шинжилгээний үр дүн, шинэ бүтээл, оюуны өмчийг эдийн засгийн эргэлтэд оруулж, уул уурхай, боловсруулах аж үйлдвэр, эрчим хүч, зам тээвэр, логистик, эрүүл мэнд, хөдөө аж ахуйн салбаруудын бүтээмжийг нэмэгдүүлэх, 3 дугаарт шинжлэх ухаан, технологийн салбарт төр, хувийн хэвшлийн түншлэл бүхий адилтгах санхүүжилт болон хувийн хэвшлийн судалгаа хөгжүүлэлтийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлсэн

татварын таатай орчныг бий болгох, 4 дүгээрт хэрэглээний шинжлэх ухаан, хиймэл оюун, дижитал бизнес, ногоон технологи, гарааны бизнесийг дэмжих, инновацын хөрөнгө оруулалтын санг байгуулан ажиллуулах, 5 дугаарт дэлхийгээр тархан ажиллаж байгаа нарийн мэргэжлийн Монгол инженер, академик ажил эрхэлж буй эрдэмтэд, мэдлэг ур чадвар эзэмшиж буй Монгол оюутнуудын ур нарийн ур чадвар, хүний нөөцийн мэдээллийг бүрдүүлэх, тэдгээрийн мэдээлэлд суурилсан бодлогын чиглэлийг тогтоон гадагш урсах тархины урсгалыг эргүүлэн татах үндэсний хөтөлбөрийг батлан хэрэгжүүлэх.

6 дугаарт Монгол Улсын хөгжлийн асуудалд шийдвэрлэх үүрэг бүхий шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх чиглэлийн салбар дундын болон салбар дамнасан үндэсний судалгаа хөгжлийн төслийг хэрэгжүүлэх, 7 дугаарт Шинжлэх ухааны паркийн эрх зүйн байдлын тухай анхдагч хуулийн үзэл баримтлал хуулийн төслийг боловсруулан батлуулж, Шинжлэх ухааны паркийн ТЭЗҮ, бүтээн байгуулалтад шаардагдах хөрөнгө оруулалт, санхүүжилтийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр шийдвэрлэх, 8 дугаарт Цахим шилжилтийг эрчимжүүлж, их өгөгдөл, хиймэл оюун, технологи, мэдээлэлд суурилсан нээлттэй шинжлэх ухааны үйлчилгээ нэвтрүүлэх, 9 дүгээрт их өгөгдөл, хиймэл оюун, супер компьютерын тооцоонд суурилсан виртуал цахим шинжлэх ухааны паркийн.../минут дуусав/

**Ж.Золжаргал:** 3 номерын микрофон нэмэлт хугацаа өгье.

**И.Батхүү:** Инновац гарааны бизнесийн үйл ажиллагааг эрхлэх татварын хөнгөлөлттэй чөлөөт бүс буюу шинжлэх ухаан, технологийн паркуудыг бүсчлэн хөгжүүлэх, 10 дугаарт шинжлэх ухааны хүрээлэнгүүдийн нэгдсэн цогцолбор, технологи дамжуулах төв, салбар дундын нээлттэй нээлттэй лабораторийг байгуулан шаардлагатай дэд бүтцийг бий болгох зэрэг бодлогын арга хэмжээг авч ажиллахаар төлөвлөж байна. Анхаарал тавьсанд баярлалаа.

**Ж.Золжаргал:** Асуултаас өмнө би зүгээр нэг зүйлээс тодруулаад яачихъя. Нөгөө инновацын эрх зүйн орчин, инновацын бодлогын тогтолцоо болоод Инновацын тухай хууль, Шинжлэх ухаан технологийн тухай хууль тэр эрх зүйн орчны засварлах хэрэгцээ шаардлага юу байна вэ? Энэ тал дээр та танилцуулга дээрээ нэмээд тайлбар хийгээд өгөөч. 4 номер, 4 номероо нээж өгье.

**Д.Баттогтох:** Эрх зүйн орчин дээр өнөөдөр тулгарч байгаа зүйл бол Шинжлэх ухаан технологийн хууль өнгөрсөн хаврын парламентын чуулганаар шинэчлэн найруулахаар батлагдсан байгаа, 18 жилийн дараа гэсэн үг. Үүнтэй холбогдуулаад тэр хууль дээр гарсан гол өөрчлөлт энэ хуулиар зөвхөн судалгаа хөгжүүлэлтийн асуудлыг биш инновац, бизнес хөгжүүлэлттэй шинжлэх ухааныг холбох бүх зохицуулалтууд орсон байгаа. Өнөөдрийн яг ЗГ-ын бүтэц, бүрэлдэхүүний тухай хуульд орсон өөрчлөлтөөр инновацын асуудал нь Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам дээр байгаа. Шинжлэх ухаан технологийн асуудал Эдийн засаг, хөгжлийн яам дээр байгаа. Тэгэхээр шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагааг эдийн засгийн эргэлтэд оруулахад гол гүүр болдог зохицуулалт бол эрх зүйн зохицуулалт Инновацын хуулиар зохицуулна.

Тэгэхээр энэ бодлого хууль, эрх зүйн зохицуулалтын асуудлууд нь өөр яаманд шилжсэнээр хэрэгжилтийг хангахад хүндрэлтэй нөхцөл үүсэж байгаа. Ер нь шинжлэх ухааны байгууллагууд, технологи хөгжүүлж байгаа байгууллагуудын гол санал бол шинжлэх ухаан технологийн асуудалтайгаа инновац нь нягт нэг

хэрэгжилтийн газар дээрээ зохицуулагдаж явах юм бол илүү үр дүнтэй байна гэсэн саналтай байгаа.

**Ж.Золжаргал:** Баярлалаа. Баттогтох дарга танилцуулга хийсэнд баярлалаа. Инновац, шинжлэх ухаан, инновацыг эдийн засагжуулах, шинжлэх ухааны бүтээгдэхүүн, инновац нэвтрүүлэх, тэрийгээ эдийн засгийн үр ашигтай байлгах, тэгээд цаашдаа мэдлэгт тулгуурласан эдийн засагтай болох гээд нэг ийм том зорилтын хүрээнд ЗГ-ын бүтцийн өөрчлөлтүүд хийгдээд, тэгээд энэ салбар нь хуучин энэ Боловсролын яаманд байсан, Эдийн засаг руугаа явсан гэж ерөнхий ийм ойлголт байгаа. Одоо зүгээр тогтолцооны хувьд яах вэ гээд саяын Баттогтох даргын ярьдаг асуудал дээр бүгдээрээ өнөөдөр нэлээн анхаарч хэлэлцье гэж бодож байна.

Мэдээлэлтэй холбоотой асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Цэнгүүн гишүүнээр, Галбадрах гишүүнээр тасаллаа. Ундрaм гишүүний микрофон нээж өгье.

**Ч.Ундрaм:** Ер нь манай энэ шинжлэх ухааны салбарын өнөөдрийн байгаа байдал манай улс хэр их олон асуудалтай байна гэдгээс л харагдаж байгаа. Бид өөрсдийнхөө асуудлыг шийдэж чадахгүй ийм хэмжээнд байна. Утаа, түгжрэл, хөрсний бохирдол, тэгээд гадаад руу махаа ч олигтой экспортолж чадахгүй, мал нь өвчиндөө баригдаад, хөрсний доройтол гээд. Тэгэхээр бид яг өнөөдөр хамгийн түрүүнд тулгамдсан асуудлуудаа эрэмбэлээд ийшээгээ бүх энэ шинжлэх ухааны бодлогоо нэн түрүүнд явуулмаар байгаа юм. ШУТС 8,9 тэрбум, 6 тэрбум төгрөгийг 399 төсөлд зарцуулсан гэж би ойлголоо түрүүний илтгэлээс. Тэгэхээр энэ чинь 390-ээс бараг 400-гаад төсөлд энэ мөнгийг хувааж өгнө гэдэг бол том хэмжээний судалгаа хийх ямар ч боломжгүй. Зүгээр л дусаагаад, дусаагаад явж байна гэсэн үг.

Тэгэхээр энэ улс орныхоо асуудлуудыг эрэмбэлж байгаад, эхний хамгийн чухал хэдэн юм руугаа л энэ шинжлэх ухаанд зориулагдаж төсөвлөгдсөн мөнгөө чиглүүлж ажиллавал яасан юм бэ? Бид угаасаа цөөхөн шинжлэх ухааны хүний нөөцтэй болохоор бүх юм руу орох ямар ч боломжгүй. Тийм хүчин чадал бид нарт байхгүй. Тэгэхээр ингэж нэг ийм чиглэсэн бодлого ойрын хэдэн жил явуулбал яасан юм бэ гэсэн ийм зүйл байна.

Энэ web of science-д бүртгэлтэй сэтгүүлд хэвлүүлсэн өгүүллийн тоо мөн Scopus бүртгэлтэй сэтгүүлийн H индексээрээ Азид эхний 21-д орлоо гээд мундаг бүтээлүүд гарсан байна л даа. Энэ яах аргагүй манай эрдэмтдийн маш том амжилт. Гэхдээ бид ингээд Англи хэл дээр нээлттэй хэвлүүлээд л орхичихдог. Энийг бид Монголд хэрэглэх ёстой байхгүй юу. Хэрэглэхийн тулд Монгол хэл дээрээ энийгээ ойлгуулж, сурталчилж, компаниудад танилцуулж энийг та бүхэн ингэж энэ нээлт бүтээлийг ашиглаж болно гээд ингэж нөгөө дараагийн түвшин рүү нь бид явуулмаар байгаа юм. Бид нарын нэг номерын зорилго өгүүлэл хэвлүүлэх биш, бид нарын нэг номерын зорилго асуудлыг шинжлэх ухаанчаар шийдэх. Тэгэхээр энэ чиглэл рүү явбал яасан юм бэ?

Дараагийн энэ манай докторант оюутнуудаас л хүсэлт ирээд байгаа юм. Энэ web of science-д бид нэвтрэх эрхтэй болмоор байна эсхүл Scopus-тай сэтгүүлүүдийг уншдаг болмоор байна. Яг энэ та хэдийн research 4 life эд хэрэгтэй л дээ ... эд нар. Гэхдээ дийлэнх бид нарын унших гээд байгаа сэтгүүлүүд энэ web of science-д ялангуяа бүртгэлтэй байна. Ийшээгээ орох эрхийг нь нээж өгөөч, тэгж байж бид шинжлэх ухааны бүтээл судалгаагаа ахиулна гэсэн ийм асуулт байгаад байна. Тэгэхээр энэ дээр нэгдсэн та бүхний барьж байгаа бодлого байна уу?

Дараагийн асуудал plagiarism. Би өмнө нь нэг чуулган дээр хэлсэн. Бид ерөөсөө хуулагч.../минут дуусав/

**Ж.Золжаргал:** Нэмэлт цаг өгье. Ундрам гишүүн.

**Ч.Ундрам:** Хуулагч үндэстэн болчихоод байна. Энэ ахисан түвшний магистр, доктор, бакалаврын ажил ч гэсэн хийж байгаа нөхдүүд маш их хуулж байна. Дээрээс нь хиймэл оюун ухаан гээд ийм юм гараад ирчихсэн. Тэгэхээр энэ дээр нэгдсэн бодлого бид хэрэгжүүлэхгүй бол улс үндэстнээрээ зүгээр хуулаад сайхан амьдраад болчихдог юм гэсэн ийм дадал төлөвшил бий болох гээд байна. Тэгэхээр энэ дээр ямар бодлого та бүхний зүгээс барьж байгаа вэ?

**Ж.Золжаргал:** 3 номерын микрофон дээр хариулт өгнө. Батхүү дарга.

**И.Батхүү:** Ундрам гишүүний асуултад хариулъя. Таны хэлж байгаатай санал нэг байна. Ер нь улс орон, нийгэм эдийн засагт тулгараад байгаа томоохон асуудлууд дээр үндэсний энэ чадварлаг эрдэмтэд, судлаачдын нөөцийг ашиглах, бүтээлийг нь эрэмбэлэх, чухал асуудлууд руугаа илүү хуваарилах, тэгээд энэ судалгааных нь үр дүнг ч гэсэн сайн байлгах үүднээс ахиухан дүнтэй, цөөн томоохон судалгаануудыг хийх гэдэгтэй санал нэг байна. Таны дурдсан хөрсний бохирдол, ялангуяа хөдөө аж ахуйн, мал аж ахуйн тогтолцоог зөв болгох, малыг эрүүлжүүлэх зэрэг асуудлууд бол энэ эдийн засгийг төрөлжүүлэх үнэхээр чухал, нийгмийн ч гэсэн чухал асуудлууд байна. Цаашдаа энэ чиглэл дээр анхаарч ажиллана.

2 дугаарт нь хэвлүүлсэн бүтээл энийгээ Монгол хэл дээр хувийн хэвшил, бизнест танилцуулах, хэрэглээнд нэвтрүүлэх, бизнесийн эргэлтэд оруулах тал дээр мөн санал нэг байна. Харин зарим улс орнуудын туршлагыг харвал их, дээд сургуулиудаасаа өгсүүлээд энэ судалгаа дээр эрдэмтэд, судлаачид оюутнуудтайгаа хамтраад хувийн хэвшлийн, бизнесүүдийн захиалга судалгааны тэргүүлэх чиглэлтэй нийлээд анхнаасаа хамтарч ажилладаг. Үүнийгээ цаашаа бүүр старт ап компани болгоод явуулдаг сайн туршлагууд бий. Монголд ч гэсэн энэ судалгаанд суурилсан их сургуулийн тогтолцоог хөгжүүлэх чиглэлээр цаашдаа энэ эрдэм шинжилгээний байгууллагууд ч гэсэн энэ эдийн засагт илүү эргэлтэд оруулах талаар энэ идэвхтэй ажиллах ёстой гэдэгтэй санал нэг байна. Үлдсэн 2 асуудлыг манай Баттогтох дарга хариулчихъя.

**Ж.Золжаргал:** 4 дүгээр микрофон.

**Д.Баттогтох:** Ундрам гишүүний асуултад хариулъя. Web of science, do..., scopus гээд мэдээллийн сангуудын тодорхой эрхүүдийг Шинжлэх ухаан, технологийн төрийн захиргааны байгууллагаас төсөвт тусгаж аваад, тэгээд гол ШУА, томоохон их, дээд сургуулиудад эрхийг нь хэрэглүүлдэг. Гэхдээ энийг илүү нээлттэй болгох тал дээр бид цаашид энэ талын зардлыг нэмэгдүүлээд ажиллах шаардлагатай гэдэг дээр санал нэг байна.

Хуулбарлалтай холбоотой бол Хуулбарлалтын зохицуулах журмыг баталсан байгаа. Хуучин БШУЯ байхад энэ журам боловсруулагдаад батлагдсан. Тэгэхээр энэ хуулбарлалтыг шалгахын тулд бид нарт эхлээд big data үүсгэх шаардлага байгаа. Тэгэхээр энэ датаг бид ШУТС дээр хамгаалалт хийгдсэн докторантур болоод магистр оюутнуудын бүтээлүүд хадгалагддаг. Үүнээс гадна таны түрүүн дурдсан тэр олон судалгааны үр дүнгүүд 4000 гаруй судалгааны үр дүн бол энэ сан дээр хадгалагддаг байгаа. Тэгэхээр энэ дата, тэгээд дээр нь хувийн хэвшилтэй

хамтарч бид энэ plagiarism яг хуулбарлалтыг шалгах программаа хөгжүүлж байгаа. И сантай хамтарсан. И сан өөрөө маш сайн дата цуглуулсан байсан. Тэгэхээр 2 талаас датагаа нийлүүлээд, эхний байдлаар бид 20 гаруй диссертацыг хуулбарлалтыг нь шалгаж, үр дүнг нь гаргасан байгаа.

Цаашдаа энийгээ хэрхэн тэр мэдээлэл хоорондын солилцоог зохицуулж явах вэ гэдэг дээр тодорхой шийдэл гаргахгүй бол яг ШУТС-д төвлөрсөн бүх датануудыг И сан руу ингээд нээлттэй өгөхөөр асуудлууд үүсэх магадлалтай гэдэг байдлаар бид энэ дээр Боловсролын яамтай ярилцаад, тэгээд он гаргаад шийдлээ гаргаад явахаар ийм шийдвэртэй байгаа.

Түрүүн тэр ер нь сан дээр маш олон төсөл хэрэгжиж байгаа. Энийг тодорхой улсын асуудал үүсэж байгаа тэр төсөл асуудлыг нь шийдэх эсхүл яг улсын тэргүүлэх чиглэлтэйгээ холбогдуулаад төслүүдээ нэлээн мега маягаар хэрэгжүүлэх нь үр дүнтэй гэдэгтэй санал нэг байгаа. Энийг зохицуулсан зохицуулалт нь Шинжлэх ухаан, технологийн хууль дээр үндэсний судалгаа хөгжүүлэлтийн төслийг хэрэгжүүлэх зохицуулалтууд орсон. Энэ 25 оны 1 сараас, 1 сарын 1-нээс энэ үндэсний судалгаа хөгжүүлэлтийн төсөл зарлагдаад хэрэгжээд явах юм. Тэгэхээр энэ дээр нэлээн том дүнтэй яг түрүүн дурдсан шинжлэх ухаан технологийн тэргүүлэх чиглэл, цөм технологийн төслүүдээ хэрэгжүүлээд явахаар ингэж төлөвлөж байгаа.

**Ж.Золжаргал:** Та тэр үндэсний судалгаа хөгжүүлэлтийн төслийн чиглэл нийт хэмжээ том дүнтэй гэсэн шүү дээ. Тэр нь ямар хэмжээтэй байх талаар мэдээлэл өгөөч? 4 номер.

**Д.Баттогтох:** Бид бүхэн 26 он хүртэл Монгол Улсын шинжлэх ухаан технологийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлсон. Энэ дээр хүний хөгжлийн судалгаа, хөгжүүлэлт, хүнс, хөдөө аж ахуй, хүрээлэн буй орчин, ногоон хөгжил, эрчим хүчний судалгаа, аж үйлдвэрийн судалгаа, өндөр технологийн судалгаа гээд дотроо 2-оос 3 цөм технологиудыг баталсан байгаа. Тухайлбал аж үйлдвэр дээр нүүрс шингэрүүлэх, төмрийн хүдэр, зэсийн баяжмал, уран, нүүрсийг боловсруулах технологи, газрын ховор элементийг боловсруулах гэх мэт технологиудаа нарийн заагаад өгчихсөн. Үндэсний судалгаа хөгжүүлэлтийн төслийг бид мөнгөн дүнгийн төсөөлөхдөө 1-ээс 5 тэрбумын хооронд хэлбэлзэх тийм үндэсний судалгаа хөгжүүлэлтийн төсөл байна гэж харж байгаа. Тэр нь ТЭЗҮ-ийн өмнөх превизибл... маягийн урьдчилсан ТЭЗҮ-ийн түвшинд хүрэхээр тийм нарийн судлагдсан судалгаанууд гарна гэж ойлгож байгаа.

**Ж.Золжаргал:** Баярлалаа. Дараагийн асуулт Цэнгүүн гишүүн асуултаа тавина уу. Цэнгүүн гишүүний микрофон нээж өгнө үү. Улсын Их Хурлын гишүүн Цэнгүүний микрофоныг нээж өгье.

**С.Цэнгүүн:** Бүгдэд нь өдрийн мэнд хүргэе. Тэгэхээр шинжлэх ухаан, технологи, инновацын салбарыг өөрөө Эдийн засгийн хөгжлийн яаман дээрээ авч байгаа гэдэг шалтгаан нь бид эдийн засгийн эргэлтэд оруулах гээд байгаа юм байна гэж ойлгож байна. Тэгэхээр нэг харагдаад байгаа зүйл нь болохоор маш олон судалгаанууд өнгөрсөн хугацаанд хийгдсэн. Тэгээд яамнууд дээр ч гэсэн салбар салбараараа 200, 300 саяар ингээд л судалгаанууд хийгээд байдаг. Гэхдээ судалгаануудаа бид ерөөсөө амьдрал дээр хэрэгжүүлэхгүй байгаад байдаг асуудал байгаад байна.

Тэгэхээр ер нь зүгээр сүүлийн үед хараад байх нь манай Монголчууд дандаа судалгаа гэж ярьдаг ч гэсэн тэр судалгаа дээр тулгуурласан дүгнэлтүүдийг амьдрал дээр хэрэгжүүлж чадахгүй байгаа учраас энэ судалгааны үнэ цэнүүд ерөөсөө байхгүй байгаад байгаа юм. Тэгээд 1 зүйлийг асуумаар байгаа нь болохоор энэ Стандарт хэмжил зүйн газартай танайх яаж яг хамтарч ажиллаж байгаа вэ? Яагаад вэ гээд тэгэхээр инновацлаг шинэ бараа бүтээгдэхүүнүүдийг оруулж ирээд бизнесийнхэн амьдралд ашиглаад эхэлье гэхээр Стандарт хэмжил зүйн газраас MNS стандарт яг Монгол Улсын үндэсний стандарт болго гэдэг шаардлагыг тавьдаг. Тэрийгээ тавих гэхээр Стандарт хэмжил зүйн газар дээр нь төсөв байхгүй учраас бизнесийнхэн өөрсдөө хий гээд ийм юу тавьчихдаг.

Тэгээд байж байнгуут үндсэндээ ингээд харахаар энэ инновацыг нэвтрүүлэхийн тулд энд бараг 50, 70 тэрбумыг ч гэсэн ингээд тавьчихсан байна шүү дээ. Тэгэхээр энийг ер нь аль газраа, хэн нь хийх ёстой байгаад байгаа юм бэ? Манай Монгол Улс инновацлаг улс байхыг дэмжээд эндээ төсөв тавьчихсан байгаад байдаг хэр нь яг бодит амьдрал дээр ороод ирэхээр иргэд жишээ нь шинэ технологи инновац нэвтрүүлье гээд өөрсдөө судлаад оруулаад ирэхэд энд хаалттай байгаад байдаг. Тэгэхээр энэ Стандарт, хэмжил зүйн газартай холбоотой асуудлыг асуумаар байгаа юм.

Тэгээд нэг зүйл байна л даа. Жишээ нь энэ цахилгаан станцууд дээр нүүрсний цахилгаан станцууд дээр байгаа үнсний асуудал байгаа юм. Үнсэн сав нь дүүрчихсэн, тэгээд салхилангуут Улаанбаатарт тоосонцрын хэмжээ маш өндрөөр явагддаг. Бусад улс оронд энэ үнсийг бид фильтрээр дахин боловсруулаад, тэгээд барилга ч юм уу эсвэл замын материалуудад ашиглаад явдаг. Энийг яг цахилгаан станцынхантай яриад бид энэ үнсээ дахин ашиглах боломж байхгүй юм гээд хэлэхээр үгүй ээ уг нь бол боломжууд байгаа. Гэхдээ Монгол Улсад стандарт нь байхгүй болохоор бид энэ төрлийн үйлдвэрүүдийг ашиглалтад оруулж чадахгүй байгаа юм гээд ийм зүйл хэлээд сууж байгаа юм.

Стандарт хэмжил зүйн газраас асуухаар нөгөө л бид нарт төсөв мөнгө нь байхгүй гэдэг юм ярьж байгаа юм. Тэгэхээр энэ мэт яг ингээд Монгол Улсад тулгамдчихсан байгаа энэ асуудлуудаа судлаад, тэр стандартыг нь батлуулаад, гол нь амьдралд хэрэгжүүлэх тал дээр нь яаж уялдаа холбоотой ажиллах юм бэ? Тэгэхгүй бол бид нарт гоё нэртэй цаас байлаа гээд үнэхээр хэрэггүй шүү дээ. Тэгэхээр яг энэ цааснуудыг яаж амьдрал дээр хэрэгжүүлэх юм бэ?

**Ж.Золжаргал:** Энэ талаар 4 номер Баттогтох дарга хариулт өгнө үү.

**Д.Баттогтох:** Цэнгүүн гишүүний асуултад хариулъя. Ер нь бид нарын гол шүүмжлэгддэг өнцөг та бүхэн маш олон цаас гаргаад тэгээд тэр чинь амьдрал үйлдвэрлэлд үйлчилгээнд нэвтрэхгүй байна гэдэг асуудал. Тэгээд энийг бид энэ шинэ эрх зүйн орчноороо нэлээн шийдлийг нь гаргаж хуульчилсан. Гол асуудал тухайлбал Стандарт хэмжил зүйн газартай хэрхэн хамтарч ажиллаж байна гэхээр стандартуудыг батлахад манай эрдэмтэд зөвлөж, тэр стандартуудын яг үндэслэл томъёолол бүх зүйл дээр нь оролцож ажилладаг. Гэхдээ яг бүгд дээр нь гэж хэлж чадахгүй байна. Тэгэхээр зарим нэг стандартууд өөр ажлын хэсэг багаа бүрдүүлээд ингээд гардгийг үгүйсгэхгүй.

Ер нь шинжлэх ухааны талаасаа эрдэмтэн судлаачид, их дээд сургуулийн багш талаасаа яг энэ стандарт батлах үед нь, боловсруулах үед нь оролцох бүрэн бололцоотой. Энэ нь нээлттэй байгаа. Ер нь манай шинжлэх ухаан, технологи,

инновацын салбарт зарцуулж байгаа яг судалгаа, хөгжүүлэлт, инновацын зардал нийтдээ 10 орчим тэрбум, дунджаар сүүлийн 10 жилийн дунджийг авах юм бол 6-аас 10 тэрбум байгаа. Тэгэхээр саяын бид нарын танилцуулга дээр дурдсан 49 тэрбум гэдэг бол урсгал зардал буюу цалин, бусдаар гүйцэтгүүлэх тэр зардлууд дээр нэмэх нь саяын миний дурдсан судалгаа хөгжүүлэлттэйгээ нийлээд энэ тоо 49 тэрбум гэж гарч байгаа. Яг нөгөө судалгаа шинжилгээнд зарцуулж байгаа зардал нь 10 тэрбум гэдгийг би цохоод мэдээлэл өгчихье.

Технологи ер нь үнстэй холбоотой манай ШУА-ийн Хими, химийн технологийн хүрээлэн гээд олон эрдэмтэд шийдлүүдийг нь гаргасан. Бид бүр барилгын материал ингэж хийж болно хаягдал үнсээр, эрдэмтэд ч гэсэн туршиж үзүүлсэн. Тэгээд уг нь шийдэл технологи нь эрдэмтдийн хувьд гарсан. Тэрийг яг цааш нь хэрэгжүүлж авч явах тэр институтийн санал санаачилга дутмаг байдгаас бол ингээд яг биет бүтээгдэхүүн болж, үйлчилгээ болж гарч болж, гарч явж чадахгүй байгаа гэж харж байгаа. Тэгэхдээ энийг бид тэр цаас үнэгүйдээд байгаа орон зай буюу технологи дамжуулах төвүүд, мөн шинжлэх ухааны паркийн хөгжүүлснээрээ энэ орон зайг нөхөж, яг үйлдвэрлэлийн салбарыг шинжлэх ухааны салбартай холбож ажиллах ийм бүрэн бололцоотой дэд бүтэц үүсэх юм байна гэж харж байгаа. Тэгээд тийм учраас 25 онд Шинжлэх ухааны паркийн тухай хуулийг боловсруулж, батлуулаад үүнтэй хамтаар бол технологи дамжуулах төв хамтын оффис гээд энэ хамтрах орчныг бүрдүүлдэг тэр дэд бүтцүүдийг хөгжүүлэх тал дээр төлөвлөгөө гаргаж ажиллаж байгаа.

**Ж.Золжаргал:** Цэнгүүн, 3 номерын хариултыг сонсчихъё эхлээд.

**И.Батхүү:** Цэнгүүн гишүүний асуултад нэмэлтээр хариулъя. Ер нь зөвхөн шинжлэх ухаан, технологи, инновацын салбар гэлтгүйгээр ер нь эдийн засаг, нийгмийн бүхий л салбарт энэ стандартыг чанд мөрдүүлэх энэ асуудал маш чухал асуудал байдаг. Ер нь батлагдсан стандартыг төлбөр төлж худалдаж авдаг асуудлыг байхгүй болгоё гэдэг асуудлыг манай яамны зүгээс их тавьж, анхаарч ажиллаж байгаа. Одоо бидний элссэн олон улсын холбооныхоо дүрмээр заавал нэг төлбөртэй байх ёстой гэсэн асуудал яриад байдаг юм байна лээ. Тэгэхдээ байх ёстой бол аль болох хамгийн бага төлбөр хураамж төлдөг, олон нийт, аж ахуйн нэгж, бизнесүүд энэ стандартуудыг нээлттэй, илүү их мэдээлэлтэй хэрэглэдэг байх тал руу анхаарч ажиллаж байгаа.

Цаашдаа ч гэсэн энэ олон улсад гарч ирж байгаа шинэ технологи ялангуяа Монголд орж ирж байгаа шинэ, шинэ салбарууд бизнестээ хэрэгцээ шаардлагатай технологио стандартыг нь хөрвүүлж орчуулж, батлуулах ажлыг бас ирээдүй харсан чиглэлээр бизнестэйгээ хамтраад холбогдох яамнууд нь анхаараад, зөвхөн нэг агентлагийн асуудал гэж үзэхгүйгээр анхаарч ажиллах нь зүйтэй гэж санал нэг байна.

**Ж.Золжаргал:** Цэнгүүн гишүүн тодруулна.

**С.Цэнгүүн:** Тэгэхээр энэ стандарттай холбоотой зүйлийг бид ер нь харах хэрэгтэй болчихоод байгаа юм. Энэ чинь өөрөө ер нь өрсөлдөөнийг хязгаарлагч хүчин зүйл нөгөө талаасаа болчихоод байгаа шүү дээ? Нэг компани ч байдаг юм уу, нэг брэндийг илүү бусдаас нь давуу талтай болгохын тулд зөвхөн энэ стандартын бүтээгдэхүүнийг оруулна гээд тендер дээр ч байдаг юм уу ингээд зарлаад өгчихдөг. Тэгээд хараад үзэхээр ялгаагүй чанарын үзүүлэлттэй ч гэсэн тухайн стандарт гэдэг нэрээс нь болоод шинэ өрсөлдөөн орж ирж болдоггүй ийм байдал үүсчхээд байгаа

юм. Тэгэхээр бид энэ стандартаар далимдуулж нөгөө монопол байдлыг төрөөр хийлгээд байж болохгүй байгаад байгаа юм л даа.

Тэгээд дээрээс нь нэг зүйл харахад MNS стандартыг бид зайлшгүй үндэсний стандарт болгож оруулах ёстой гээд, шинэ бүтээгдэхүүн болгон дээр тавьчаад байгаа юм. Гэтэл энэ маань болохоор Монголд үнэхээр үйлдвэрлэх гээгүй юм бол тэртээ тэргүй гаднаас ЕИ ч байдаг юм уу ISO стандартаараа стандартынхаа юунд лабораторийнхоо шинжилгээтэй байгаа бүтээгдэхүүн импортолж оруулж ирж байхад түүнийг бид үндэсний стандарт болгоно гэдэг чинь бид нарт тэрийг үндэсний стандарт болгож авах лабораторийн чинь хүчин чадал байхгүй байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ маань өөрөө угаасаа л зүгээр худлаа.../минут дуусав/

**Ж.Золжаргал:** Нэмэлт хариулт 3 дугаар микрофон.

**И.Батхүү:** Тантай санал нэг байна. Ер нь энэ стандарт гэдэг маань зайлшгүй байх хамгийн доод шалгуур үзүүлэлт гэдэг агуулгаараа ер нь байж байх ёстой. Түүнээс өрсөлдөөнийг хязгаарлах аливаа нэг байгууллага ААН-д давуу тал олгох тийм асуудал байж болохгүй. Энэтэй санал нэг байна. Цаашдаа энэ олон улсын стандартыг заавал Монгол хэл дээр бүртгүүлэх гэдэг асуудлыг ч гэсэн бизнесийг илүү чөлөөтэй, нээлттэй болгох гэдэг дээр энэ бодлогын чиглэлтэй уялдуулаад дахиж судалж үзэх шаардлагатай гэж үзэж байна. Баярлалаа.

**Ж.Золжаргал:** Стандарт Монгол оронд ямар нэгэн шинэ юм нэвтрүүлэх үйл ажиллагаа явуулахад аюулгүй, хүнд аюулгүй, байгальд хор хөнөөл багатай тэгээд тэр нь л хамгийн чухал. Тэрнээс биш стандартаар дамжуулаад аль нэгэнд нь давуу байдал эсвэл нэг боодог эсвэл нөгөө бүтээгдэхүүндээ тааруулж хиймэл стандарт зохиодог иймэрхүү зүйлс байж болохгүй шүү дээ. Тэгээд энэ стандартыг боловсруулахад нэг ажлын хэсэг гаргаад л, тэгээд баахан зардал гаргаад аягүй төвөгтэй байдаг юм л даа. Ер нь ийм манайхаас хөгжлийн түвшин өндөр нөгөө евро норм ISO энэ тэрийг оруулж ирэхэд илүү жоохон хөнгөвчилсэн байдлаар явчихдаг нэг ийм л баймаар байгаа юм. Тэгээд энийг магадгүй бид ер нь Их Хурлын хамаарах асуудал стандарт тийм ээ, ярилцах, нэг шийдэлд хүрэх хэрэгтэй байх.

Юуны тэр цахилгаан станцын үнсний тухайд би энэ дээр өөрөө ажиллаж байсан болохоор нэмээд нэг коммент хэлчихмээр байна. Энэ цементийн үйлдвэрүүд нөгөөхийг нь авмаар байдаг, авах гэхээр аягүй төвөгтэй ингээд манайд ийм гаргадаг гоожуур байхгүй энэ тэр гээд байдаг. Тэгээд тэр юмнуудыг бид энэ магадгүй Байгаль орчны чиглэлээр байнгын хороотой ч юм уу, эрчим хүчнийхэнтэй яриад, Засгийн өмнөөс ажлыг нь хийх гээд байгаа юм биш л дээ. Тэгэхдээ энэ байж байгаа бодлогыг хэрэгжүүлэх талаас нь Цэнгүүн гишүүн бид хамтарч энэ асуудлыг босгоё гэж бодож байна. Дараагийн асуулт Анар гишүүн. Анар гишүүний микрофоныг нээж өгье.

**Ч.Анар:** Өдрийн мэнд. Утаа, түгжрэл, дэд бүтэц, нийгмийн энэ бүх л асуудлууд угаасаа шинжлэх ухаанч биш шийдвэр гаргаж байгаа. Шинжлэх ухааны салбарын дуу хоолой байхгүй. Энэ бүх л асуудал энэ дээр байгаа. Энийг Ундрам гишүүн ч ярьж байна, би ч санал нэг байна, та бүхэн ч гэсэн санал нэг байгаа байх. Тэгэхээр 3 асуулт байна. Шинжлэх ухаан ач холбогдолтой гээд бид социализмын үеэс ярьсан байх. Та бүхэн бас л санал нэг байх. Энэ 1998 оны 55 дугаар тогтоолоос өгсүүлээд л, 2017 оны ЗГ-ын 295 дугаар тогтоол, Баялгийн сангийн тухай хууль, Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн тухай хууль, Үндсэн хуулийн



Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал бүх юманд шинжлэх ухаан ач холбогдолтой гээд заачихсан байгаа.

Та бүхний танилцуулга дээр байж байна. 1990 оноос шинжлэх ухааны салбарын боловсон хүчин 3 дахин буурсан байна. Азийн дунджаас 3 дахин бага, Финляндаас 14 дахин бага. Тэгэхээр шинжлэх ухаан хэрэгтэй гэдэг нь хэн бүхэнд ойлгомжтой. Тэгээд бид энэ салбартаа орох ёстой, энэ салбараа тэргүүлэх чиглэл болгоод явах ёстой та бүхэнтэй бүгдээрээ бид нар, ард түмнээрээ санал нэг байгаа. Тэгээд энэ бодит байдал нь юу болоод байгаа юм бэ гэхээр хөгжиж байгаа улсууд хамгийн доод тал нь 0,5-аас 1,5 хувийн төсвийг ДНБ-ийхээ хувь дээр тавьдаг. Өндөр хөгжилтэй улсууд 2-оос 4, зарим улсууд 7 хувь дээрээ тавьсан. Тэр улсуудад энэ утаа байхгүй, түгжрэл байхгүй, нийгэм, эдийн засгийн асуудал шийдэгдсэн байгаа.

Тэгэхээр манай дээр өнөөдөр ингээд ач холбогдолтой хэрэгтэйг нь бүгдээрээ ярьж байгаа. Ингээд аягүй олон үзэл, би энийг бүр ингээд тоолж болохгүй, Бодлогын баримт бичгүүд байгаа байхгүй юу. Бүгдээрээ намын мөрийн хөтөлбөр, Засгийн газрын тогтоол, Их Хурлын тогтоол хуулиуд дээрээ ингээд хэрэгтэй. Тэгээд бүгдээрээ хоорондоо зөрчихсөн. 1 хувь, 2 хувь. Гэхдээ яг бодит байдал дээрээ та бүхний төсөв тэг, улам л буураад байна шүү дээ. 0,11 хувь байсан бол одоо 0,1 хувь болчихлоо. Тэгэхээр юун 1 хувь, 2 хувь, 3 хувь энэ хууль нь хэзээ хэрэгжих билээ? Тэгэхээр асуудлыг нь бид мэдэж байгаа. Тэгэхээр энэ хуульд заасан энэ төсвөө аваад шинжлэх ухаандаа үр ашигтай зарцуулах төсөвт оруулах энэ шинжлэх ухаан инновацын салбарын ач холбогдлыг таниулах улс төрийн манлайг хэзээнээс үзүүлж эхлэх вэ? Хэзээ энэ мөрийн хөтөлбөр, хуулийнхаа хэрэгжилтийг биелүүлж эхлэх вэ? Одоо энэ харахаар эхний жилдээ бүүр бодит байдал дээрээ буурчихсан байна. Энэ 1 дүгээр асуулт. 2 дугаарт тэр яам хооронд шинжлэх ухаан, технологи.../минут дуусав/

**Ж.Золжаргал:** Анар гишүүн нэмэлт минут өгье.

**Ч.Анар:** Яам хооронд инновац, шинжлэх ухаан, технологи, боловсрол гээд энэ үндсэндээ салшгүй байгаа хэсгийг бол 3, 4 салгачихсан байгаа. Энэ дээр уялдахад хэцүү байгааг нь ойлгож байна. Тэгэхээр энийг зохицуулдаг байгууллага бол бүтцийн хувьд, институтийн хувьд Шинжлэх ухаан технологийн үндэстний хороо гэж байх ёстой юм байна. Үндэсний хорооны дарга нь Монгол Улсын Ерөнхий сайд байх ёстой, 19 гишүүнтэй байх ёстой. Энэ байгуулагдсан байгаа юу? Энэ байгуулагдаагүй бол хэзээ байгуулагдах вэ? Энэ салбар хоорондын уялдааг зохицуулах.

3 дугаар асуулт нь судалгааны цааснууд хоосон цаас болдог энэ академи гээд яриад байгаа. Академи гэдэг Шинжлэх ухааны академи гэдэг байгууллага ер нь бараг Монгол Улсад л үлдсэн байх, ОХУ ч байхгүй болчихсон юм шүү дээ. Тэгэхээр энэ их сургуулиудын дэргэдэх эрдэм шинжилгээний хүрээлэнгүүдээ эдийн засгийн эргэлтэд оруулж, чадавхжуулах ажил хийгдэж байгаа болов уу? Тэр талаар тодруулъя.

**Ж.Золжаргал:** Анар гишүүн 3 асуулт. 4 дүгээр микрофон нээж өгнө үү.

**Д.Баттогтох:** Анар гишүүний асуултад хариулъя. Анар гишүүний хэлж байгаа саналтай 100 хувь санал нэг байна. Ер нь та бүхэн legal дээр хамгийн их илэрцтэй үгийг хайх юм шинжлэх ухаан гэж гарч ирнэ. Шинжлэх ухаан гэдгийг бараг бүх хууль дээр үндэслэж ингэж оруулсан байдаг хэр нь шинжлэх ухааны салбар нь

дэмжлэгийн хувьд хамгийн сул салбар болж байгаа. Тэр нь энэ эрдэмтдийн тоо санхүүжилтээр харагдаж байгаа. Тийм учраас энэ дээр 100 хувь санал нэг байна. Бид нарыг яг энэ Шинжлэх ухаан, технологийн хуулийг шинэчлээд боловсруулж байх үед Япон болоод Солонгосын эрдэмтэн судлаач, зөвлөхүүдтэй бид санал солилцож байсан. Тэгээд тэд нар бидэнд зөвлөсөн нэг зөвлөмж бол та нарын улс төрийн институт ерөөсөө хүчтэй байж чаддаггүй юм байна, ажиллаж чаддаггүй юм байна.

Тийм учраас та бүхэн ингээд шинжлэх ухааны салбартаа олигтой төсөв авч чаддаггүй, дэмжлэг авч чаддаггүй юм байна гэж зөвлөсөн. Тэгээд Японы тухайд 20, 30 жил энийгээ янз бүрийн байдлаар үзэж байж яг Ерөнхий сайдынхаа дэргэд ийм зөвлөлтэй байдаг. Тэр зөвлөл нь салбар дундын зохицуулалтыг хамарсан ийм зөвлөл байдаг гэдэг ийм зөвлөмжийг өгсөн. Энийг үндсэндээ Солонгос хуулаад ингээд хэрэгжүүлээд явж байгаа. Ерөнхийлөгчийнхөө дэргэд Шинжлэх ухаан, технологи, инновацын зөвлөл, хороо ч гэж нэрлэгддэг байгууллагууд явдаг юм.

Тэгээд яг энэ агуулгаар та зөв харсан байна. Яг шинэ хууль дээр шинжлэх ухаан, технологи, инновацын гэж инновац оруулж ирж байгаа, Үндэсний хороо гэж томъёолж өгсөн. Энэ хороог Ерөнхий сайд ахлахаар хуульчилж өгсөн байгаа. Тэгэхээр энийг бид ЗГ-ын тогтоолын төслийг нь бэлдээд, дараа долоо хоногт орохоор бүх яамнуудаас санал аваад, бэлтгэл ажлыг нь хангасан байгаа. Тэгэхээр энэ зөвлөлийн таны саяын дурдсан 19 гишүүнд гол чиглэлийн яамнууд, Аж үйлдвэр, Сангийн яам мэдээж төсөвтэй холбоотой учраас эрчим хүч гээд гол чиглэлийн яамнуудын сайд нар, дээр нь хувийн хэвшлийн төлөөллүүдийг оруулж өгсөн.

Мөн шинжлэх ухааны байгууллага гол байгууллагуудын төлөөллийг оруулж өгсөн байгаа. Тийм учраас энэ зөвлөл байгуулагдаад ажиллах юм бол нэлээн бид нарын улс төрийн дэмжлэг, бодлогын дэмжлэгийг нэлээн шат ахиулсан ийм дэмжлэгүүд гаргана гэж харж байгаа. Бид энэ 25 оны төсөв дээр төсвийн хязгаараараа 10, 12 тэрбумаа л судалгаа хөгжүүлэлтийн зардал дээр тавиулсан.нэ нь бараг л 4-өөс 5км хатуу хучилттай замын мөнгөний төсөв. Тэгээд энэ төсвөөр Монголын бүх шинжлэх ухааны салбарууд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх гэж оролддог ийм байгаа. Тэгэхдээ бид төсвийн бус эх үүсвэрийг нэмэгдүүлж байгаа.

Энийг цаашдаа 1 хувьд яаж хүргэх вэ гэхээр гол нь бид шинэ хууль, эрх зүйн орчноороо хувийн судалгаа хөгжүүлэлтэд санхүүжилтийг нэмэгдүүлэх, тэд нарыг энэ салбар луу хөрөнгө оруулалт хийх ийм зохицуулалтыг татварын хуульд оруулах ийм эрх зүйн зохицуулалт бол шинэ Шинжлэх ухаан, технологийн хууль дээр орчихсон байгаа. Тэгэхээр бид гол найдвар хувийн хэвшлийн судалгаа хөгжүүлэлтүүдийг дэмжсэн эрх зүйн орчныг бүрдүүлээд, хувийн хэвшлээс шинжлэх ухаан, технологи, инновацын салбарт нэлээдгүй хөрөнгө оруулалтыг татна гэсэн ийм төлөвлөгөөтэй байгаа. Тэрний наана бүртгэл гээд нэлээдгүй ажлууд явагдахаар байгаа. Сая юутай холбоотой хэлсэн.

ШУА-ийн тухайд нэлээн улс оронд академийн бүтэц байгаа. Мэдээж ЮНЕСКО-ийн 2003 онд ирсэн том баг манай шинжлэх ухааны тогтолцоо, шинжлэх ухааны бүтэц дээр нэлээн том зөвлөгөөг өгөөд, зөвлөмжүүд гаргасан байдаг. Энэ зөвлөмжид бид нарыг гол өгсөн нэг чухал дүгнэлт бол шинжлэх ухааны тогтолцоо нь илүү эрүүл, зөв бүтэцтэй. Харин энийгээ дэлхийн зах зээл, орон нутаг руугаа түгээн дэлгэрүүлэх, хэрэгжүүлэх тал дээр та бүхэн.../минут дуусав/

**Ж.Золжаргал:** Анар гишүүн тодруулъя.

**Ч.Анар:** Мэдээлэл өгсөнд баярлалаа. Тэгэхээр нөгөө асуудлаа хэдүүлээ ойлгож байгаа. Тэгээд хуульд заасан хуулиа хэрэгжүүлэхийг яамнаас шаардмаар байна. Энэ төсөвт Монгол Улсын ДНБ дээр хэдэн хувь дээр хүрэх ёстой гээд. Маш олон улс төрийн манлайлал үзүүлээд салбарын яамд нь төсвөө батлуулах дээр энийгээ авч орж ирж байгаа. Тэгэхээр энэ шинжлэх ухааны салбарын төлөөлөл болж байгаа Монгол Улсын ирээдүйн эдийн засгийг илүү солонгоруулаад, хүчирхэг болгох энэ яам маань улс төрийн манлайллаа үзүүлээсэй. Хэзээнээс үзүүлж эхлэх вэ гэдэг асуулт байсан. Асуудлыг нь та бид бүгдээрээ мэдэж байгаа. Тэгэхээр түүн дээр хариулж чадахгүй байх шиг байна.

Дараагийн юм нь тэр Шинжлэх ухаан технологийн үндэсний хороог ойлголоо. Их сургуулиудын дэргэдэх эрдэм шинжилгээний хүрээлэн, төрийн байгууллага, ШУА, хувийн хэвшлийн хоорондын энэ харилцан ашигтай байдаг дэлхийн жишиг.../минут дуусав/

**Ж.Золжаргал:** Академиас гадна их сургуулиудын дэргэдэх хүрээлэнгүүд хувийн хэвшил, хамтын ажиллагаа дээр дэлхийн жишгийг хэрхэн нэвтрүүлж байна вэ гэж 4 номер.

**Д.Баттогтох:** Бид бүхэн төслийг дэмжихдээ зарчмын хувьд нэлээн олон шалгуур үзүүлэлтүүдийг оруулж ирсэн. Тэрний нэг гол шалгуур үзүүлэлт нь салбар дамнасан болон салбар дундын асуудалтай төслүүдийг дэмжиж байгаа. Өөрөөр хэлбэл нөгөө транс... гэдэг ийм агуулгатай төслүүдийг дэмжиж байгаа. Тэгэхээр энэ агуулгын хүрээнд их сургууль, хүрээлэнгүүд хамтарч, хувийн хэвшилтэй хамтарч хэрвээ төсөл мэдүүлэх юм бол энэ нь төсөл дэмжигдэх нэг чухал шалгуур үзүүлэлт болж явдаг. Үүнээс гадна инновацын grant-г олгож байсан. Энэ grant бол төр, хувийн хэвшлийн хамтын санхүүжилтээр хэрэгждэг grant байгаа. Өөрөөр хэлбэл хувийн хэвшилд 60 хувиа гаргаад, 40 хувийг нь манай Шинжлэх ухаан, технологийн сангаас санхүүжүүлээд явдаг ийм төслийн шугам хэлбэр байсан. Тэгэхээр энэ мэтчилэн ер нь цаашдаа яг энэ салбар.../минут дуусав/

**Ж.Золжаргал:** Нэмэлт 1 минут өгье 4 номер дээр.

**Д.Баттогтох:** Энэ мэтчилэн ер нь цаашдаа энэ салбар дундын болон салбар дамнасан ийм зорилго бүхий төслүүдийг дэмжих дээр бол яам бодлого, чиглэлээ гаргаж, тодорхой журмууддаа өөрчлөлт ороод хэрэгжүүлээд явж байгаа.

**Ж.Золжаргал:** Хүрээлэнгүүдийн дэргэдэх, юуны сургуулиудын дэргэдэх хүрээлэнгийн талаар Анар гишүүн үг хэлэх цаг дээр та хэлэх санаагаа нэмээд хэлчхэж болох байх. Галбадрах гишүүн асуултаа асууна уу.

**Ж.Галбадрах:** Та бүхэнд өдрийн мэнд хүргэе. Энэ их чухал асуудал ярьж байгаа. Тэгээд бид Эдийн засаг, хөгжлийн яаманд шинжлэх ухааны Шинжлэх ухааны академи маань очоод тэнд хамрагдаад явж байна. Тэгээд би энэнтэй холбоотой хэд хэдэн асуулт асууя гэж бодоод байгаа юм. Ер нь хэдэн сургуулиудын дэргэд байсан тэр сая Анар гишүүн асуугаад байгаа шиг энэ хүрээлэнгүүд тэнд очоод нэгдчихээд байна вэ? Хөдөө аж ахуйн би энэ сонсож байсан, Хөдөө аж ахуйн дээдийн Хөдөө аж ахуйн их сургуулийн Мал аж ахуйн хүрээлэн бид Хөдөө аж ахуйн их сургуулиасаа гараад энэ Эдийн засаг, хөгжлийн яамны энэ академид орох хэрэгтэй байна гээд. Ингэхээр улам л би бол тасарч байна л гэж.

Өөрөөр хэлбэл бид нарын энэ шинжлэх ухааны Монголд байж байгаа энэ хөгжил гэдэг маань ерөөсөө аль ч улсад л даа их сургуулиа түшиглээд, их сургуулийн профессорын багт тулгуурлаад ингээд явдаг. Профессор нь өөрөө доороо оюутантай, докторын оюутантай, магистрын оюутантай, бакалаврын оюутантай. Докторын оюутнууд нь магистртаа заагаад, тэнд удирдаж байгаа тэр багшийн юм нь яваад, тэгээд хувийн хэвшилтэй хамтраад янз бүрийн төсөл, хөтөлбөр, өөрсдөө өөрөө өөрийгөө санхүүжүүлэх энэ мөнгө олоод удирдаад явахад профессор нь өөрөө тэр компани шиг, тэгээд хувийн хэвшил шиг ингээд ажиллаад, санхүү мөнгө олоод, оюутандаа тэр мөнгөнөөс нь төлбөрт нь нэмэр болгоод өгөөд ингээд хийгээд явдаг жишиг байдаг.

Өөрөөр хэлбэл хөлтэй гэсэн үг л дээ. Судалгаа хийгээд ингээд хамтраад явах. Тэгээд докторынхоо ажлын оюутнуудын судалгааг магиструуд нь туслаад гээд ингээд явахаар нэг цогц байдлаар энэ судалгаа ингээд явдаг. Тэгээд энэ байдал манайд энэ хэр алдагдаж байгаа вэ? Энэ Боловсролын яамнаас гараад, их сургуулиас нь гараад ингээд тэнд очихоор ер нь энэ байдал ямаршуу байдалтай явж байна гэдгийг 1 дүгээрт асууя. Ер нь бид чинь үйлдвэрлэл бөөн л асуудалтай шүү дээ Монгол Улсад. Агаарын бохирдол, усны бохирдол, хөрсний бохирдол, хүнсний аюулгүй байдал, хот төлөвлөлт гээд л. Боловсрол дээр ч гэсэн маш их хямрал ингээд байгаад байна.

Тэгээд энэ бүгдийг ингээд яг салбар салбараар нь тэр хүрээлэнгүүд нь ингээд хийх талаас тэр арга зүй чиглүүлээд тэр их сургуультайгаа ингээд хамтраад явах гэдэг асуудал их чухал. Энэ дээр яг ийм асуудал шийдээд, патент аваад, патентаа хамгаалчихсан тийм эрдэмтэд хэд байдаг юм бэ? Энэ нь ингээд амьдралд хэрэгжээд явж байгаа янз бүрийн автоматжуулалтын асуудлыг шийддэг гэдэг юм уу, энэ шинжлэх ухаанаар шийдсэн ийм патенттай, тэр нь үнэлэгдээд явдаг эрдэмтэд хэд байдаг юм бэ гэдгийг асууя.

Тэгээд ер нь судалгаанууд маань энэ амьдралд тулгараад байгаа энэ асуудлуудыг шийдэх, тэгээд Монгол Улс мега төслүүд хэрэгжүүлнэ гээд байна. Энэтэй холбоотой асуудлуудыг, бид метро барина гэнэ, туннел гэж байна. Тэгээд энэ манай уулын Богд уулын маань бүтцээс эхлээд энэ геологийнх нь ямар судалгаа байдаг юм, яадаг юм гэдэг ийм асуудлууд хэр байдаг юм бэ гэдэг асуудлыг.

**Ж.Золжаргал:** Хариултаа авчихъя тийм ээ, 4 дүгээр микрофон нээж өгнө үү.

**Д.Баттогтох:** ЗГ-ын бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт орж, шинжлэх ухаан технологийн асуудал Эдийн засгийн хөгжлийн яам дээр ирсэн. Энэ хүрээндээ зарим их дээд сургуулиудын хүрээлэнгүүдийн харьяаллын асуудал яригдсан байгаа. Их, дээд сургуулиудын харьяалалд нийтдээ 16 хүрээлэн байсан. Түүнээс 6 хүрээлэн нь Эдийн засгийн хөгжлийн яамны харьяанд шилжиж ирсэн байгаа. Тэгээд энэ шилжиж ирэх гол шалтгаан нь мэдээж Хүрээлэнгүүд өөрсдөө санаачилга гаргаж, энд шилжиж ирсэн байгаа. Үүнтэй холбоотой ер нь Боловсрол, шинжлэх ухааны яам байж байгаад шинжлэх ухаан нь Эдийн засгийн хөгжлийн яаман дээр ирснээрээ шинжлэх ухаан, технологийн бодлогын хэрэгжилтийн үйл ажиллагаа доголдсон, хэрэгжилт аль нэг байдлаар цалгардсан зүйл байхгүй байгаа. Өмнөх их дээд сургуулиудад өгдөг дэмжлэгийн хэлбэрүүд бүгдээрээ дэмжлэгийн хэлбэрээ өгөөд, хамтраад явж байгаа.

Тэгэхээр их дээд сургуулиуд маань өөрсдөө эрдэм шинжилгээний зэрэглэлд хамаарах дээд боловсролын байгууллага гэж явдаг. Тийм учраас ер нь ШУТС-гаас

манай гол тусгай сангаас авч байгаа нийт санхүүжилтийн үндсэндээ бараг 50 орчим хувийг их дээд сургуулиуд авдаг ийм байгаа. Өмнөх статистикаас харвал. Тэгэхээр бодлого болоод хэрэгжилтийн хувьд ямар нэгэн доголдолтой зүйл гараагүй.

Эрдэмтэн судлаачдын хувьд манай тусгай сан буюу ШУТС 93 онд байгуулагдсан. Энэ сан 30 орчим жил үйл ажиллагаа явуулж байгаа. Нийтдээ 21 оны байдлаар 178 тэрбум төгрөгийн санхүүжилт хийгдсэн байгаа. Нийтдээ энд 4200 гаруй төсөл хэрэгжээд, 51 мянган үр дүн гарсан байгаа. Энэ 51 мянган үр дүнгийн мянга орчим нь патент, үйлдвэрлэл нэвтрүүлэг шилжсэн бүтээгдэхүүн, тэгээд сая бид нарын дурдсан нөгөө олон улсын өндөр зэрэглэлтэй журналд хэвлүүлсэн өгүүлэл, ном зохиол, стандарт гээд олон бүтээгдэхүүн энэ 50 гаруй мянгад орж байгаа. Тэгэхээр санхүүжилт болоод гарсан үр дүнтэйгээ харьцуулах юм бол харьцангуй бүтээмжтэй явж байгаа гэж үзэж байгаа.

**Ж.Золжаргал:** 3 дугаар микрофон.

**И.Батхүү:** Галбадрах гишүүний асуултад нэмэлтээр мэдээлэл өгье. Ер нь Монгол Улсад хэрэгжиж байгаа мега төслүүд гэлтгүйгээр ер нь хэрэгжиж байгаа төслүүд маань өөрсдөө хуулиар заасан тодорхой судалгаанууд хийгдсэн, хуульд заасан шаардлагууд хангасан байх ёстой байдаг. Тухайлбал урьдчилсан болон үндсэн ТЭЗҮ-ийн судалгаа, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн үнэлгээ гэх мэтчилэн. Үүнээс гадна таны сая дурдсан томоохон төслүүд дангаараа нэг байгууллага эсвэл улсын төсвөөс ч юм уу санхүүжилт босгоход хэцүү. Олон улсын банк, санхүүгийн байгууллагуудын оролцоо, хөрөнгө оруулалт, зээл гээд олон төрлийн санхүүжилт оролцож явах шаардлагатай. Цаашид хэрэгцээ нь ч тийм байгаа.

Тэгэхээр эдгээр байгууллагууд маань юу шаарддаг вэ гэвэл яг бодитой хэрэгжүүлэх боломжтой эдийн засгийн тооцооллоос гадна сая дурдсан байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн судалгаа, тэр бүү хэл жендерийн асуудал дээр ямар асуудал үр нөлөө гаргаж болох вэ? Бусад төрлийн банкны өөрийнх нь засаглалаар шаарддаг олон төрлийн судалгааг хийсэн байхыг шаарддаг. Эд нарын аль нэг нь зөрчигдөх юм бол энэ төслүүд нь дэмжигддэггүй учраас зөвхөн Монголын дотоодын хууль тогтоомж гэхээс гадна олон улсын шилдэг энэ туршлага юу бол манай энэ том төслүүд дээрээс зайлшгүй хэрэгжээд явна гэсэн бодолтой байна.

**Ж.Золжаргал:** Галбадрах гишүүнд нэмэлт цаг өгье, тодруулга.

**Ж.Галбадрах:** Баярлалаа мэдээлэлд. Тийм л дээ, ер нь тэгээд энэ мега төслүүд дээр олон улсын гадаадын эрдэмтэн судлаачид орж ирээд юм хийгээд байдаг бол бид өөрсдөө энэ дотроосоо орох төслүүд маань ингээд зарлагдах гэж байна шүү дээ. Тэрэнд ингээд бэлдсэн эрдэмтэд маань энэ тал руугаа чиглэж яваасай гэсэн ийм хүсэлт байгаад байгаа юм. Жишээлбэл түрүүн стандарт яриад байсан. Кембриджийн стандарт гээд л Монгол Улсад бараг л 15, 6 жилийн өмнөөс хийлээ шүү дээ. Тэгээд өчнөөн сургууль дээр хийгээд, нэвтрүүлээд ингээд яваад байсан, тэгээд л хэдэн сургууль дээр дуусчхаад байгаа байхгүй юу. Тэгвэл өнөөдөр Монголынхоо төрийн сургуулиуд дээр тэр стандарт чинь өнөөдөр ингээд суугаад, боловсролын чиглэлээр жишээлбэл судалгаа хийдэг хүмүүс, тэр менежмент, тэр стандартыг өөрийн болгоод сургуулиуд дээрээ оруулаад ирвэл энэ чинь илүү цаашаа бүүр ингээд хөгжөөд явах боломж байгаа юм.

Тэгэхээр бид энэ дандаа гаднаас юм оруулж ирлээ, авлаа гэсэн бол судалгаанууд баг орж ирсэн бол тэрнээс аваад үлддэг байх нь их чухал байгаа юм гэдэг санааг хэлье. Тэгээд түрүүн хэлсэнчлэн тэр төсөв дээрээ нэмээд 1 хувьдаа хүргэх, тэр 0,11 хувь гээд.../минут дуусав/

**Ж.Золжаргал:** Баярлалаа. Ингээд гишүүд асуулт асууж дууслаа. Үг хэлэх гишүүд байвал нэрээ өгнө үү? Анар гишүүн үг хэлнэ.

**Ч.Анар:** Боловсрол, шинжлэх ухаан, технологи, инновац 4 тусдаа ойлголт. Тэгээд энэ бол Монгол Улсын ирээдүй хөгжих гол асуудал. Энэ дээрээ анхаарал хандуулахгүй бол 10 жилийн дараа ч бид утаагаа ярина, 10 жилийн дараа ч түгжрэлээ ярина, 10 жилийн дараа ч хүнсний талон ярина. Тэгэхээр энэ дээр улс төрийн манлайлал Их Хурлын зүгээс, Байнгын хорооны зүгээс, яамны сайд нарын зүгээс гаргах хэрэгтэй байна. Тэгэхээр энэ дээр би салбарын төлөөллийн хувьд та бүхэнтэй дэмжиж, энэ төсвийг хуульд заасан хэмжээнд нь хүргэх энэ бодлогын зөрчлүүдийг арилгах дээр хамтарч ажиллана.

2 дугаарт тэр хамгийн их хүсдэг юм бол энэ их сургуулиудын дэргэдэх эрдэм шинжилгээний хүрээлэн лабораториуд эд нар маань олон улсын манай Засгийн тусламжаар биш олон улсын төсөл, хөтөлбөрийн байгууллагууд Жайка, Энэтхэгийн тусламж, Койкагийн хүрээнд дэлхийн жишигт нэг үеэ бодвол нэлээн сайн хүрчихсэн байгаа. Тэгэхээр түүн дээр байгаа эрдэмтэн судлаач, докторант, магистр оюутнуудыг эдийн засгийн нэмэлт орлого олох боломжийг нь хувийн хэвшилтэй хамтраад үүсгэх бүрэн бололцоо байгаа, бүрэн байгаа. Би өөрөө нэлээн олон их сургуулиудаар яваад үзээд, танилцаад, хамтраад ажиллаад ирсэн хүний хувьд.

Тэгэхээр энэ бодлого бол бид шинээр зохиож байгаа ч биш, олон улсын жишиг. Тэнд л шинжлэх ухаан хөгжинө, тэнд л инновац бүтнэ. Эдийн засгийн эргэлтэд орно. 20, 30 жил ярьж байгаа үр дүнг бид тэндээс л гаргаж ирж, хариултыг нь олох ёстой. Тэгэхээр энэ дээр хамтарч ажиллаад, тэр багш эрдэмтнээ одоо бол бид Монгол Улс чадвартай хүмүүсээ дандаа гадагшаага алддаг бодлоготой байгаа шүү дээ. Тэгэхээр энэ гуравласан энэ их сургуулийн дэргэдэх лаборатори, эрдэм шинжилгээний хүрээлэнгүүдийн харилцааг бүүр нэн яаралтай сайжруулаад, эдийн засгийн эргэлтэд оруулах дээрээ хамтраад ажиллах шаардлагатай байна. Баярлалаа.

**Ж.Золжаргал:** Баярлалаа. Энэ сая Анар гишүүний дурдаж байгаа гадагшаага тархи гол хүмүүсээ алдаад байна гээд. Яамны танилцуулга дээр гадаадад байгаа Монгол судлаач нарын мэдээллийг нэгтгэсэн ийм бааз хөгжүүлнэ гээд түрүүн дурдсан. Тэгээд энэтэй холбоотой та бүхэн тэр дээрээ нэлээн анхаарч ажиллаарай гэж хүсмээр байна.

Тэгээд яах вэ бид өнөөдөр гол мэдээллүүдээ авлаа. Инновацыг тогтолцооны хувьд Цахим бодлого, инновац, харилцаа холбооны яаман дээр инновацын бодлого явж байна. Шинжлэх ухаан нь болохоор Эдийн засаг, хөгжлийн яаман дээр явж байна. Энэ 2-ыг нэгтгэх үү гэдэг нэг ийм том асуулт нээлттэй үлдэж байгаа. Тэгээд энэ өнөөдөр бид шууд ингээд шийдчихгүй, яамдтай ярина, тэгээд магадгүй хэрвээ үндэслэл байна гэх юм бол Байнгын хорооноос тогтоол гаргах уу, үгүй юү гэдгээ бид хэлэлцэнэ.

Инновацын тухай хуулийн 12 онд батлагдсан хууль 10 гаруй жил болчихлоо. Тэгэхээр энэ дээр нэмэлт, өөрчлөлтүүд, түүнтэй холбоотой татварын хуульд

оруулах өөрчлөлт, орон нутгийн хуульд, орон нутгийн зүгээс дэмжлэг оруулах ийм заалтууд гээд гааль, НӨАТ-аас чөлөөлөх тухай энэ тэр гээд иймэрхүү зохицуулалтуудыг хийх шаардлага байгаа. Энийгээ Байнгын хороон дээрээ хийнэ гэж төлөвлөж байгаа. Стандарт бол инновацлаг бүтээгдэхүүнийг дэмжихэд илүү хэрэгтэй, саад болох, хойш нь татах, сөрөг үйлчилгээ үзүүлэхгүй байх шаардлагатай байна гэдэг асуултыг өнөөдөр бид нэлээн чухалчилж ярилаа. Тэгэхээр энэ Эдийн засгийн байнгын хорооны харьяалах асуудал дээр стандартын асуудал байдаг юм байна. Тэгээд энэ талаар бид Байнгын хороонд ярьж байгаад, нөгөө талтайгаа ярьж, хялбаршуулах, түргэвчлэх талаас нь асуудлыг шийдэх хэрэгтэй юм байна гэж.

Нөгөө шинжлэх ухаан, технологи, инновацын хөгжлийг дэмжих санхүүжилт нөгөө ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.3.7 дээр ДНБ-ий 1 хувьд хүргэнэ. 4.3.1.2 дээр Үндэсний баялгийн сангийн 1 хувийг зарцуулна гээд ийм давхардсан 2 жоохон зөрөөтэй. Гэхдээ цаад агуулга нь энэ шинжлэх ухаан, технологийг хөгжүүлмээр байна гээд. Тэгэхээр энэ бол ЗГ-ын чинь ингээд парламент баталчихсан үйл ажиллагааны хөтөлбөрийг тэгээд энийг бид хэрэгжүүлэх шаардлагатай. Хэрэгжүүлэх, хяналт тавихыг нь, Үндэсний аюулгүй байдал дээр 2 хувь байгаа гэж байна. Тэгэхээр энэ асуултыг бид хуулиа хэрэгжүүл гэдэг шаардлагыг Байнгын хорооны зүгээс Инновац, цахим бодлогын байнгын хорооны зүгээс тавина гэж. Иймэрхүү зүйлсийг ингээд хэлэлцүүлгийн төгсгөлд цохон тэмдэглэмээр байна.

Тэгээд би нэг зүйлийг хэлмээр байна. Шинжлэх ухааны хөгжил, бүх юм нөгөө инновац гээд ингээд хэрэглээнд нэвтрэх ёстой гэдэг зүйлийг бид маш их ярьж байгаа. Эдийн засгийн үр ашигтай байх ёстой гээд үнэн. Тэгэхдээ суурь шинжлэх ухаан байхгүй бол технологи байхгүй, инновац байхгүй, мэдлэгт тулгуурласан бизнес ч байхгүй. Математикийн онолын судлаачид байж энэ улс чинь тархитай байна жишээлбэл. Онолын физик байна, хими байна. Тэгээд юм болгон дээр ингээд бүтээгдэхүүн байх ёстой, инновац байх ёстой. Тэгэхгүй бол санхүүжилтийг нь бууруулдаг ч юм уу ийм зүйл байж болохгүй. Тэгэхээр энийг яах вэ зориуд цохон тэмдэглэмээр байна. Та бүхэн мэдээж энэ салбарын хүмүүс асуудлаа маш сайн мэдэж байгаа. Суурь шинжлэх ухаан гэж юу вэ, технологи, инновац. Тэгээд энд нь ингээд цогцоор нь хөгжүүлэх талдаа тал талаасаа анхаарч ажиллая гэж хэлмээр байна. Ингээд бүгдэд нь баярлалаа. Гишүүд үг хэлж дууслаа.

12.41 цаг

***Хоёр.Улсын Их Хурлын 2024 оны 05 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаарх Харилцаа холбооны зохицуулах хорооны даргын мэдээллийг сонсох***

Хэлэлцэх асуудал хоёртоо орно. Хэлэлцэх асуудал 2. Улсын Их Хурлын 2024 оны 05 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаар. Тэр дундаа дотоодын роуминг үйлчилгээг нэвтрүүлэх талаар Харилцаа холбооны зохицуулах хорооны даргын мэдээллийг сонсоно. Албан тушаалтнууд байраа эзэлж байх хооронд нь 2 минут завсарлалчихъя.

Хэлэлцэх асуудалтай холбоотой хүрэлцэн ирсэн ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны ТНБД-ын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Алтан-Од, Харилцаа холбооны зохицуулах хорооны дарга Чинзориг, Ажлын албаны дарга Лувсан-Очир, Зохицуулалтын газрын дарга Батболд, Радио давтамжийн зохицуулалт, хяналтын газрын дарга Амгалан,

Хуулийн хэлтсийн дарга Ууганбат, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Бодлого, төлөвлөлтийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Батзаяат, яамны Харилцаа холбооны хэрэгжилтийг зохицуулах газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Баясгалан, Бодлого, төлөвлөлтийн газрын Харилцаа холбооны хөгжлийн бодлого хариуцсан ахлах шинжээч Эрдэнэ, Сансрын холбооны хэлтсийн радио давтамжийн бодлого зохицуулалтын асуудал хариуцсан шинжээч Онончимэг ирээгүй байгаа юм байна. Энэ 2-ыг, ирсэн байна уу? Ирсэн байна. Харилцаа холбооны хэрэгжилтийг зохицуулах газрын Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн зохион байгуулалт хариуцсан мэргэжилтэн Самданжамц ирсэн байна.

Мэдээлэл холбооны операторуудын ассоциацийн гүйцэтгэх захирал Тамир, Тамир захирал, Жи-Мобайл компанийн Техник хариуцсан захирал Энх-Амгалан, Мобиком корпорацийн Технологийн газрын захирал Ганзориг, Мобиком корпорацийн Бодлого зохицуулалтын албаны дарга Буянтогтох, Ондо компанийн гүйцэтгэх захирал Мандуул, Ондо Холдинг Хууль хариуцсан захирал Одмаа, Скайтел компанийн технологийн газрын захирал Батжаргал, Юнител компанийн техник хариуцсан дэд захирал Бат-Эрдэнэ, Юнител компанийн Эрсдэлийн удирдлага хууль комплайнс хариуцсан дэд захирал Пагмасүрэн ийм бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг ирсэн байна.

Тэгээд энэ асуудлын хүрээнд төрийн байгууллагуудаас гадна оператор компаниудын байр суурийг сонсьё гэсэн зорилгоор бүгдийг нь урьж оролцуулж байгаа. Тэгээд оршил болгоод хэлэхэд энэ Монгол Улсын харилцаа холбооны тухай хууль 2014 оны 7 дугаар сарын 1-нд гурвын, 25.2.9 дээр хэрэглэгч дугаартайгаа цахилгаан холбооны үйлчлэгч хооронд шилжих техникийн боломж бүрдүүлэх гээд үйлчлэгчийн хүлээсэн үүрэг дээр нэмсэн байдаг 2014 онд. Үүнийг хэрэгжүүлэх нь энэ салбарт энэ олон удаан жил ажиллаж байгаа хөрөнгө оруулагчдын хувьд хүндрэлтэй асуудал их байна, цаг нь болоогүй байна, шаардлага хэрэгцээ шаардлага нь ямар байна вэ гээд нэлээн ийм маргаантай сэдвүүд явсан. Та бүхэн бүгдээрээ мэдэж байгаа байх.

Тийм болохоор тэгвэл дугаар шилжих асуудлыг шийдэгдтэл түр орхиод, шаардлагатай үед сүлжээгүй газар хоорондоо холбогдоод байгаа сүлжээгээр нь дамжуулаад ярьдаг болчихъё гэсэн энгийнээр хэлбэл. Иймэрхүү агуулгаар 2024 оны 1 дүгээр сард Улсын Их Хурлын 5 дугаар тогтоол гарсны нэг заалт нь 5 дугаар заалт нь байгаа. Тэгээд энэ ингээд Монгол Улсын Их Хурлын дарга Занданшатар гарын үсэг зураад, энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Улсын Их Хурлын Инновац, цахим бодлогын байнгын хороонд Батшугар даргын үед даалгасугай гэсэн ийм тогтоол байдаг.

Би энийг уншиж өгье. Цахим шилжилтийн суурь дэд бүтэц болох харилцаа холбооны дэд бүтцийн давхардсан хөрөнгө оруулалтыг багасгах, дэд бүтцийн ашиглалтыг нэмэгдүүлж, иргэдийг хөдөлгөөнт интернэтээр тасралтгүй, найдвартай, хүртээмжтэйгээр хангах зорилгоор дотоодын роуминг дэд бүтэц хуваарилах болон бусад олон улсын туршлага, арга хэлбэрийг судалж, төр хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан нэвтрүүлэх боломжийг бүрдүүлэх гэж. Тэгэхээр өнөөдөр бол яг энэ асуудлын хүрээнд танилцуулгаа хийгээд, тэгээд Их Хурлын дэгээрээ асуултаа богино хугацаанд минутаар асуулт, хариултаа яваад ингээд шуурхайнхан хэлэлцье гэсэн саналтай байна.



Асуултын хүрээнд Харилцаа холбооны зохицуулах хорооны дарга Чинзориг танилцуулга хийнэ. 4 дүгээр микрофон нээж өгнө үү.

**Г.Чинзориг:** Инновац, цахим бодлогын байнгын хорооны гишүүд та бүхэнд энэ өдрийн мэндийг дэвшүүлье. Харилцаа холбооны зохицуулах хороо нь хуулийн хүрээнд харилцаа холбооны зах зээлд үр ашигтай, шударга өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх, хувийн хөрөнгө оруулалтыг дэмжих чиглэлээр ажилладаг байгууллага. Өнөөдөр харилцаа холбооны дэд бүтэц, сүлжээг өргөжүүлэх, үр ашигтай ашиглах чиглэлээр үндсэн 2 арга хэмжээг танилцуулахаар бэлдсэн байгаа. 1 дүгээрт нь үндсэн сүлжээний хөрөнгө оруулалтыг давхцуулахгүйн тулд үндсэн сүлжээний төлөвлөлтийг хянаж үзэж ажиллаж байгаа. 2 дугаарт нь үүрэн холбооны хэрэглэгч яаралтай түргэн тусламжийн дугаарт ямар ч тохиолдолд шуурхай холбогдож, төрийн үйлчилгээг цаг алдалгүй авах эрхтэй. Энэ хүрээнд үүрэн холбооны үйлчилгээ эрхлэгчийн сүлжээний хамрах хүрээнээс шалтгаалан зарим тохиолдолд хэрэглэгч яаралтай түргэн тусламж, зориулалтын дугааруудтай холбогдоход хязгаарлагдмал байдаг тулд энэ дээр бид бүхэн 2018-аас 2024 оны хугацаанд ажлын хэсэг байгуулж ажилласан. Энэ ажлын хүрээнд бид 5 операторуудтайгаа нийлж технологийн шийдэл гаргаж, энэ маань амжилттай болох шийдэл гарсан байгаа. Энийг өнөөдөр бид бүхэн танилцуулахаар бэлдсэн байж байгаа. Энийг танилцуулна.

2 дугаарт ерөнхийдөө 5 оператор маань энэ 112 дугаарыг хэрэглэгчийн сүлжээ хязгаарлалтгүйгээр ард иргэдэд хүргэхийн тулд технологийн шийдлүүдээ гаргаж тавьсныг өнөөдөр бид бүхэн яг слайдаар та бүхэнд танилцуулна гэж бодож байгаа. Ингээд дэлгэрэнгүй мэдээллийг бэлдсэн байж байгаа. Та бүхэнд танилцуулъя. Бодлого, зохицуулалтын газрын дарга манай Батболд дарга. Лувсан-Очир дарга танилцуулах юм байна.

**Ж.Золжаргал:** 3 дугаар микрофон нээж өгнө үү.

**А.Лувсан-Очир:** Инновац, цахим бодлогын байнгын хорооны дарга гишүүдэд энэ өдрийн мэнд дэвшүүлье. Харилцаа холбооны зохицуулах хорооны гишүүн, Ажлын албаны дарга Лувсан-Очир байна. Монгол Улсын Их Хурлын 2024 оны 5 дугаар тогтоолын зарим заалтын хэрэгжилтийн талаар товч танилцуулга хийе. Танилцуулгын эхэнд Харилцаа холбооны салбарын статистикийн үндсэн үзүүлэлтийг мэдээлэл болгож танилцуулъя. Интернэтийн суурин холболтоор холбогдчихсон гэрээлсэн хэрэглэгч 2024 оны эхний хагас жилийн байдлаар 523711 хэрэглэгч бүртгэгдсэн байна. Энэ нь Монгол Улсын нийт өрхийн 50,3 хувийг эзэлж байгаа юм. Интернэтийн суурин интернэтэд холбогдсон өрхийн 94,49 хувь нь өрхийнх, 5,51 хувь нь байгууллагын хэрэглэгчид байна. Нийт хэрэглэгчдийн 95,66 хувь нь шилэн кабелиар холбогдсон. Мөн нийт хэрэглэгчдийн 94,4 хувь нь 10 мегабайт секундээс дээш хурдаар гэрээлсэн ийм статистик мэдээлэлтэй байна.

Интернэтийн бөөний урсгалын үйлчилгээг 4 оператор компани хэрэгжүүлж байна. Жем нэт, Нэт ком, Мобиком нэтворкс, Эм Ти Нэтворкс гэсэн 4 компани нийтдээ 53 ISP компанид 218,2 мегабайт секундийн бол урсгалыг гэрээний үндсэн дээр нийлүүлж байна. Wholesaling хийж байгаа буюу бөөний үйлчилгээ эрхэлж байгаа ААН-ийн нийт урсгалын багтаамж нь 720,5 гигабит секундийн багтаамжтай байж байна. Үүрэн холбооны үйлчилгээгээр дамжуулан хөдөлгөөнт интернэтийн зурвас буюу хөдөлгөөнт интернэтийн үйлчилгээг хүргэж байна. 2024 оны эхний хагас жилийн байдлаар 4061500 3 болон 4G хэрэглэгчид бүртгэгдсэн байна. Энэ нь 100 хүнд ноогдох олон олон улсын аргачлалаар тооцоход 100 хүнд ноогдох цэгийн

тоо 115,9 буюу дэлхийн дунджаас дээгүүр үзүүлэлттэй байна. Эхний хагас жилийн байдлаар мобайл интернэт хэрэглэгчдийн хэрэглээ нь 388153 терабайт хэрэглээг үүсгэсэн байна. Энэ нь хөдөлгөөнт интернэт хэрэглэгчдийн хувьд 1 сарын дундаж хэрэглээ нь 15,9 гигабит хэрэглээг хэрэглэсэн байна.

Өнөөдрийн хэлэлцэх асуудлын хүрээнд яригдах мэдээлэл холбооны сүлжээний үндсэн статистик мэдээллийг дэлгэцийн баруун гар талд харуулсан байна. Монгол Улсын хэмжээнд харилцаа холбооны сүлжээ байгуулах 19 тусгай зөвшөөрлийг 12 ААН-д олгосон байна. Нийтдээ Монгол Улсын хэмжээнд 52480км шилэн кабелийн сүлжээ байгаагаас хот хоорондын сүлжээ буюу үндсэн сүлжээнд 46686км, хот доторх сүлжээнд 5794км сүлжээ байгуулагдсан байна. Үндсэн сүлжээ болох хот хоорондын сүлжээний 46,58 хувийг төрийн өмчийн Мэдээлэл холбооны сүлжээ хувьцаат компанийн ашиглалт үйлчилгээг хариуцаж байгаа бол 22,22, 25,22 хувийг Скай нэтворкс, 19,79 хувийг Мобиком нэтворкс, үлдсэн хувийг нь бусад ААН-үүд ашиглалт үйлчилгээг нь хариуцан ажиллаж байна.

Мэдээлэл харилцаа холбооны сүлжээнд давхардсан хөрөнгө оруулалтыг багасгах, дэд бүтцийн ашиглалтыг нэмэгдүүлэхтэй холбоотойгоор Монгол Улсын ЗГ-аас 2013 оны 6 тоот тогтоолоор сүлжээг шинээр байгуулах, түүний эдийн засгийн урт хугацаанд үр өгөөжтэй байх талаар зохицуулалт хийх ийм арга хэмжээний чиглэлийг тодорхойлж өгсөн байдаг. Уг тодорхойлолтын хүрээнд ХХЗХ-ноос энэ мэдээлэл холбооны сүлжээ байгуулах тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлага дээр тухай бүр нэмэлт, өөрчлөлт нөхцөл шаардлагуудыг тавьж ажилласан байгаа. Ингээд 2013 оны ЗГ-ын 2013 оны 6 дугаар тогтоолыг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор 2013-аас 19 он хүртэл сүлжээний давхардал, сүлжээний хөрөнгө оруулалтыг үр ашигтай байх талаар ХХЗХ-ноос жил бүр дүгнэлт гаргасан.

Уг дүгнэлтийн дагуу үйлчилгээ эрхлэгчид хот хооронд буюу үндсэн сүлжээгээ байгуулж ажиллаж байсан. 2020, 21, 22 онд ковидын нөхцөл байдалтайгаар сүлжээний өргөтгөл хийхтэй холбоотой дүгнэлт гараагүй. 2024 онд нэг компаниуд нь дүгнэлт гаргасан. Уг хүсэлтийг 1 дүгээрт сүлжээний найдвартай ажиллагааг хангах, 2 дугаарт сумдын түвшинд шилэн кабелийн холболтыг бий болгох талаар Дорноговь болон Сүхбаатар аймгийн нэр бүхий сумдыг холбохтой холбоотой 400 гаруй километр сүлжээ байгуулахтай холбоотойгоор дүгнэлт гаргаж ажиллаж байсан.

Сүлжээний давхардал, хөрөнгө оруулалтыг багасгах, мөн дэд бүтцийн ашиглалттай холбоотойгоор зохицуулалтын үндсэн 4 үе шатыг тодорхойлж авч үзэж байгаа. Сүлжээний төлөвлөлт, сүлжээ байгуулах, сүлжээ хамгаалах сүлжээний ашиглалтын гээд. Энэ асуудлыг энэ зохицуулалтын энэ үе шатыг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор зөвхөн харилцаа холбооны салбар өөрийн дотоод баримт бичгийн зохицуулалтын хүрээнд хийгдэхээс гадна салбар хоорондын зохицуулалтын асуудал нэн шаардлагатай байгааг онцгойлж хэлье. Тухайлбал сүлжээ төлөвлөлттэй холбоотойгоор хот байгуулалтын төлөвлөлт, газар төлөвлөлтийн хүрээнд сүлжээ байгуулахтай холбоотойгоор газрын зөвшөөрлийг хялбаршуулах, барилгыг эхлүүлэх, хүлээлгэж өгөх процессыг харилцаа холбооны сүлжээ байгууллагатай нийцүүлэх, төвлөрсөн хот, суурин газруудад сайт байгуулахтай холбоотой асуудлыг Орон сууцын тухай хуультай мөн нийцүүлэх. Сүлжээ хамгаалах асуудал дээр шилэн кабелийн сүлжээний хамгаалалтын зурвас, сайтын хамгаалалтын зурвас, дэд бүтцийн бусад, хамгаалалтын зурвастай давхцуулах энэ боломжийг судлах, хууль хоорондын нийцлийг хийх гэсэн чиг үүрэгтэй.

Сүлжээний ашиглалттай холбоотойгоор газрын төлбөр, мөн барилгын болон эрчим хүчний норм норматив гэсэн ийм баримт бичгүүдийн хооронд нийцэл хийхтэй холбоотойгоор салбар хоорондын зохицуулалтын арга хэмжээг авах шаардлага үүсэж байгаа юм. Энэний хүрээнд Барилга, хот байгуулалтын яам хуучин нэрээр өмнөх ЗГ, одоо бол Хот байгуулалт, барилга, орон сууцын яам, Эрчим хүчний яам, мөн бусад байгууллагуудтай төрийн захиргааны төв байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэх, хууль хоорондын нийцэл тухайлбал Орон сууцын тухай хууль, Барилгын тухай хууль, Газрын тухай хуулийг хуулиудад энэ харилцаа холбооны салбарт мөрдөгдөж байгаа харилцаа холбоо, радио долгион зэрэг хуулиуд дээр байгаа зохицуулалтын ялангуяа сүлжээний радио сайт байгуулахтай холбоотой энэ зохицуулалтыг нийцүүлэх ийм арга хэмжээ авах шаардлага үүсэж байгаа юм. Норм нормативтай холбоотой баримт бичгүүд дээр салбар хооронд хамтран ажиллаж байна.

Дараагийн энэ Улсын Их Хурлын 5 тоот тогтоолыг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор энэ сүлжээний давхардсан хөрөнгө оруулалтыг бууруулах, дэд бүтцийн ашиглалтыг нэмэгдүүлэхтэй холбоотойгоор мэдээллийн нэгдсэн системийг бий болгох асуудал хөндөгдөж ярьж байгаа. Монгол Улсын ЗГ-ын 2020 оны энэ газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийг хэрэглээнд нэвтрүүлэх тухай 110 дугаар тогтоол, Монгол Улсын ЗГХЭГ-ын даргын 2023 оны 107 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн хүрээнд энэ харилцаа холбооны худаг, сувагчлал, кабелийн сүлжээ, түүний хамгаалалтын бүсэд газар олгох, кабель шугам таслах зэрэг хүндрэл бэрхшээлийг шийдвэрлэх талаар, мөн сүлжээний давхардсан хөрөнгө оруулалт хийхээс сэргийлэх талаарх энэ мэдээллийн нэгдсэн системийг зохион байгуулах ажлын хэсэг ажилласан.

Энэ хүрээнд Харилцаа холбооны зохицуулах хорооноос Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар үйлчилгээ эрхлэгчтэй хамтарсан 3 талт ажлын хэсэг зохион байгуулж, энэ нэтмап системийг бол хөгжүүлэлтийг хийж байгаа. Энэ нэтмап систем нь харилцаа холбооны сүлжээний дэд бүтцийн орон зайн мэдээллийн нэгдсэн сантай холбогдох ийм чиг үүрэгтэй. Ингэснээрээ сүлжээний давхардал мэдээллийг төрийн захиргааны төв байгууллагууд мөн үйлчилгээ эрхлэгчид нэг source-оос нэг эх сурвалжаас авах ийм бололцоо бүрдэнэ гэж үзэж байгаа. Нөгөө талдаа үйлчилгээ эрхлэгчид аль чиглэл рүү хөрөнгө оруулалт хийж, сүлжээгээ өргөтгөх, мэдээ мэдээллийг авах ийм бололцоотой гэж үзэж байгаа юм. Сүлжээний давхардалтай холбоотой хийж байгаа ажлын талаарх товч мэдээлэл өгөхөд ийм байна.

Дараагийнх нь, дараагийн слайд дээр дотоодын роумингийн үйлчилгээг нэвтрүүлэх хүрээнд даргын хэлсэн дээр тодотгож хэлэхэд яаралтай тусламжийн үйлчилгээ буюу бид хэдийн мэддэг 100, 101, 102 гэдэг энэ дугааруудаар авдаг яаралтай тусламжийн үйлчилгээг national роумингийн энэ зарчмыг ашиглаж хэрхэн шийдвэрлэх талаар ажилласан талаар товч тайлан хүргэе. Үүссэн нөхцөл байдлын хүрээнд үзэхэд сүүлийн үеийн гар утаснууд 112 гэдэг нэгдсэн дугаарлалтыг өөрийн үйлдлийн систем дээрээ тусгаж өгснөөр энэ нэгдсэн дугаарлалттай яаралтай тусламжийн үйлчилгээг бий болгох бололцоо бүрдсэн байгаа. Гэхдээ өнөөдрийн Монгол Улс дахь нөхцөл байдал 101, 100, 102, 103, 105 гээд салангид ийм систем ашиглагдаж байгаа. Энийг нэгдсэн системд бий болгох шилжүүлэх ийм шаардлага үүссэн байна гэж үүссэн нөхцөл байдлаа дүгнэж байгаа. Авах арга хэмжээний хүрээнд 2018 онд бид Төв аймгийн Мандал сум буюу Батсүмбэртэй үүрэн холбооны үйлчилгээ эрхлэгчидтэйгээ хамтраад тухайн үед ашиглагдаж байгаа одоо ч ашиглаж байгаа энэ 101 гэдэг дугаарлалт дээр бид энэ nationa

Мөн роумингийн зарчмыг ашиглаж туршилтын ажил хийсэн. Мөн 2024 оны 3-аас 4 дүгээр сар дээр үйлчилгээ эрхлэгчидтэй хамтран Улаанбаатар хот болон Багануур Налайх дүүргүүдэд өрөө холбооны 2G, 3G, 4G систем дээр гар утасны симтэй, симгүй, мөн дата симтэй гэсэн ийм горимоор энэ нэгдсэн дугаарлалт болох 112 дээр тухайн хэрэглэгч өөрөө аль операторын хэрэглэгч байхаас үл хамаараад яаралтай тусламжийн дуудлага, үйлчилгээ авах боломжийг туршиж үзсэн байгаа. Ингэснээр улсын хэмжээнд яаралтай тусламжийн нэгдсэн дугаарлалтад шилжих бололцоотой байна гэсэн урьдал дүгнэлтийг хийгээд байна.

Цаашид хийх зохицуулалтын төлөвлөгөөний хүрээнд 2 үндсэн ажлыг төлөвлөж байгаа. Үүний хүрээнд 1 дүгээрт Монгол Улсын харилцаа холбооны сүлжээний дугаарлалтын нэгдсэн төлөвлөгөөнд 112 гэсэн нэгдсэн дугаарлалтыг тусгаж өгөх. 2 дугаарт нь салангид байгаа энэ дугаарлалтыг чөлөөлөх, өөр дугаар луу шилжүүлэх ийм зохицуулалтын арга механизмыг авахаар төлөвлөж байна. Энэ арга хэмжээг хэрэгжүүлсэн ач холбогдлын хүрээнд үзвэл яаралтай тусламжийн хүрээнд улсын хэмжээнд нэгдсэн дугаарлалттай болох, нэгдсэн дугаарлалтыг бий болгосноор тухайн хэрэглэгч аль операторын хэрэглэгч байхаас үл хамаараад тухайн магадгүй операторын сүлжээ нь 2G, 3G, 4G сүлжээнд нэвтэрснээс мөн үл хамаараад, мөн симтэй байх, байхгүйгээс үл хамаараад 112 гэдэг нэгдсэн дугаарлалтаар дугаарт хандаж, яаралтай тусламжийн байгалийн болон бусад давагдашгүй нөхцөлөөс тулгарсан, нөхцөл тулгарсан төрийн ийм үйлчилгээг авах ийм бололцоотой. Өөрөөр хэлбэл тусламжийн үйлчилгээ авах бололцоо бүрдэнэ гэж үзэж байгаа юм.

Дараагийн слайд нь. Хийж буй зохицуулалтын хүрээнд роуминг, үндэсний роуминг буюу дотоодын роуминг үйлчилгээний хүрээнд зохицуулалтын хүрээнд хийгдэж байгаа ажлуудын талаар энэ слайдаар танилцуулъя. ХХЗХ-ноос 2015 онд энэ дэд бүтцийг хамтран ашиглахтай холбоотой зохицуулалтын судалгаа хийж, үйлчилгээ эрхлэгч нараар хэлэлцүүлсэн. Тухайн үед энэ судалгаа, судалгаанаас гарсан үр дүн гэвэл бизнесийн зарчмаар явах шаардлагатай юм гэж үзсэн байгаад байгаа. Ингээд технологийн шинэчлэлттэй холбоотойгоо, шинэчлэлт нэвтэрч өөрчлөгдөж байгаатай холбоотойгоор 2022 оноос дахин энэ дотоодын роуминг буюу national роумингийн асуудлыг судалж үзсэн. Гэхдээ энэ дээр бид идэвхгүй дэд бүтцийн хүрээнд, идэвхгүй дэд бүтэц гэдэг нь байр, талбай, цамхгийг хамтран ашиглахтай холбоотой асуудлаар 2022 онд нэг хэлэлцүүлэг хийсэн байна. Мөн Улсын Их Хурлын энэ 5 тоот, 24 оны 5 тоот тогтоол гарсантай холбоотойгоор идэвхгүй дэд бүтцийг хамтран ашиглахтай холбоотой зохицуулалтын журмын төслийг боловсруулж, 25 оны 2 дугаар сард үйлчилгээ эрхлэгч нараар хэлэлцүүлэхээр бэлтгээд байна.

Цаашид зохицуулалт, зохицуулалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх төлөвлөгөөний талаар дунд талын баганаар товч танилцуулга хийе. Тус хорооноос 2025 онд энэ Харилцаа холбооны идэвхгүй дэд бүтцийг хамтран ашиглах зохицуулалтын журмыг боловсруулж, үйлчилгээ эрхлэгч нараар хэлэлцүүлж, ямар шийдлээр цаашдаа ашиглах бололцоотой байгаа талаар хэлэлцэхээр төлөвлөж байгааг хэлсэн. Өнөөдрийн нөхцөл байдлын хүрээнд яг идэвхгүй дэд бүтцийг яаж ашиглаж байгаа талаарх товч мэдээллийг өгье. Мэдээлэл холбооны сүлжээ компанийн хувьд 399 цамхаг, 463 байршилд техникийн байр өрөөг бүрэн share-лэж, түрээсэлж ашиглах бололцоог олгож байгаа. 2 дугаарт үйлчилгээ хэрэглэгчдийн хувьд 4323 цэгт сайт байгаагаас 2313 сайт буюу нийт өөрсдийн сүлжээнийхээ 65.../минут дуусав/

**Ж.Золжаргал:** 3 номерын микрофон нээж өгнө үү, нэмэлт цаг.

**А.Лувсан-Очир:** Бусад үйлчилгээ эрхлэгчдийн хувьд 4323 сайт байгаагаас 2813 сайт буюу нийт сайтынхаа 65 хувийг хуваан ашиглах бололцоог нээж өгсөн байна. Энэ 2 статистик мэдээллээс харахад мөн ирээдүйд шинээр нэвтрэх буюу 5G технологийг нэвтрүүлэх хүрээнд цамхаг дээр байршуулах, цамхгийн ашиглалтын асуудал бол 20-оос 50 орчим хувиар нэмэгдэх ийм төлөвтэй байна гэдэг урьтал статистик судалгаа гарсан байна.

Төгсгөлд нь хэлэхэд энэ идэвхгүй дэд бүтцийг хамтран ашиглах энэ зохицуулалтыг хийснээр мөн сүлжээний хөрөнгө оруулалт буурах, шинэ технологийг нэвтрүүлэх хөрөнгө оруулалт буурах, дэд бүтцийг хамтран ашиглах ашиглалтын нөхцөл байдал сайжирна гэсэн ийм үр дүнтэйгээр дүгнэлтийг хийж танилцуулгаа өндөрлөж байна. Баярлалаа.

**Ж.Золжаргал:** Танилцуулга хийсэнд баярлалаа. Би яах вэ энэ асуулт хэлэлцүүлэг яахаас өмнө гишүүдээсээ асуучихъя гэж бодож байна. Энэ юуны нөгөө бусад талын мэдээллийг сонсчхоод, тэгээд асуулт руугаа орвол, орчихвол зүгээр байх тийм ээ. Тэгэхээр энэ Улсын Их Хурлын 5 дугаар тогтоолын 5 дугаар зүйл нь дотоодын роумингийн тухай. Саяын танилцуулга дээр дурдлаа л даа. Нөгөө яаралтай үед холбоо барих 112 дугаарын сүлжээ оператораас үл хамаараад ямар ч үед залгаж болохоор шийдэл боловсруулсан гээд. Тэгээд энэ бол их сайшаалтай зүйл байна. Та бүхэндээ талархлаа талархлаа илэрхийлмээр байна. Энийг харин яаралтай нэвтрүүлэх хэрэгтэй.

Гэхдээ 5 дугаар тогтоол бол ослын үед, яаралтай үед залгах утасны дугаартай холбоотой биш. Агуулга нь энэ чинь нөгөө хөдөө орон нутагт хээр явж байгаад тэгээд 1 оператортай нь сүлжээ нь байхгүй болчихоор нөгөөх нь байж байдаг, тэрүүгээрээ ороод залгадаг, магадгүй тэр нь өндөр төлбөртэй байдаг. Монголчууд гадаад руу явахаараа Хятад руу яваад, Хятадын оператораар дамжаад өндөр төлбөр төлөөд утсаар ярьдаг шүү дээ. Эсвэл гадаадын хүн Монголд ирчхээд Монголын оператораар дамжаад өөрийнхөө оператор дээр илүү мөнгө төлөөд утсаар ярьдаг. Тэгэхээр яаралтай үед та бүхний саяын танилцуулсан тэр яаралтай үед холбогдохоос гадна, ажил төрлийн холбоотой, ар гэртэй асуудалтай ийм холбоо барих хэрэгсэл, үүнийг ингээд дугаартайгаа шилжих нь маш их хүнд юм.

Том дугаар, дугаарууд чинь өөрөө үнэ цэнтэй. Өчнөөн олон жил ажиллаад, хөрөнгө оруулаад бизнесийн үнэ цэн үүсгэчихсэн. Тэгээд ингээд шилжчихээр зэрэг жижиг рүүгээ ингээд урсгал алдах. Тун бүдүүлгээр болхиор тоймлож ярихад иймэрхүү хүндрэл байгаа учраас тэр асуудлыг ингээд түр орхиод, хэрэгтэй үед хүмүүс хөдөө гадаа хаана ч явсан нэгнээрээ дамжаад холбоотой болчихъё гэдэг ийм агуулгаар энэ тогтоолыг гаргасан. Тэгээд энэ тогтоолыг гаргаж байх үеийн хүмүүстэй бид ярилцаж, мэдээлэл авсан л даа. Тэгэхээр 1 дүгээрт ийм яаралтай үед иргэдийн зүгээс энэ хэрэгцээ шаардлага нь байгаад байна шүү дээ. Гадаад руу гараад роуминг хэрэглэдэг, дотооддоо бид яагаад энийг хэрэглэж болохгүй байна. Төлбөрийг нь өндрөөр тавиад, ингээд тариф яахаар тэр бол нэг их айхтар тэлэхгүй. Тэлээд л ингээд оператор солиод байх юм байхгүй. Яг хэрэгтэй үедээ тэр хүн холбогдох боломжтой л байх ёстой гэдэг энэ агуулгаар хэрэгжүүлэхэд та бүхэн ингээд цаашид дараагийн хүмүүс мэдээлэл хийхдээ яг юу нь болохгүй байгаа юм бэ, ямар хэмжээний зардал гарчхаад, яагаад хэрэгжүүлж болохгүй байгаа юм бэ гэдэг дээр анхаараасай гэж бодож байна. Яг ийм л хариултыг хүмүүс хүсээд байна.

2 дугаарт нь энэ тогтоол 2024 онд багтааж хэрэгжих ёстой тогтоол. Сая Харилцаа холбооны зохицуулах хорооны танилцуулга дээр ингээд 25 оны 2 дугаар сард бид нөгөө хэлэлцүүлэг хийнэ гээд нөгөө нэг идэвхгүй дэд бүтцийг хамтарч ашиглах талаар нэлээн урагшаа явчихсан ажил сонсогдлоо. Тэр нь сайшаалтай. Гэхдээ тогтоолын хэрэгжилтийн хугацаа чинь өнгөрчихсөн байна шүү. Монгол Улс хуультай. Тэгээд хууль бид харилцаа холбооны зохицуулах, Харилцаа холбооны тухай хууль дээр бүүр дугаартайгаа шилжих нөхцөлийг бүрдүүлэх гэсэн заалттай. Тэр заалтыг байг гэхэд энэ тогтоол хэрэгжих ёстой. Хэрвээ энэ хууль, тогтоол нь өөрөө хэрэгжих үндэслэлгүй, хууль нэг бол Үндсэн хууль зөрчсөн эсвэл хүний суурь эрхэд нийцдэггүй, бизнес үйл ажиллагаа явуулах жам ёсны ийм үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж байгаа ийм байх юм бол бид энэ заалтыг болохгүй байна гэдэг үндэслэлийг нь гаргаж тавиад, буцаагаад татах асуудал ярьж болно. Үгүй бол хууль гарсан хэрэгжүүлэх ёстой.

Тэгэхээр ямар асуудал үүсээд, яагаад ингээд хэрэгжихгүй хугацаа нь өнгөрөөд явна гэдэг ийм асуудал байгаа юм. Тэгээд гишүүд асуулт, хариулт явуулахаас өмнө Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны зүгээс ямархуу байр суурьтай байгаа талаар болон нэгэнт төлөөлж ирсэн энэ оператор компаниуд болоод ассоциацийн зүгээс дэгийнхээ дагуу 4 минут байх, 4 минутад багтаагаад та бүхэн мэдээлэл өгнө үү гэж хүсье. Тэгээд асуултад орёе. Баярлалаа. 5 дугаар микрофон нээж өгнө үү, Алтан-Од дарга.

**Ц.Алтан-Од:** Байнгын хорооны гишүүдийн энэ өдрийн амрыг эрье. Хөдөлгөөнт холбоо 5G технологийн асуудал бусад Улсын Их Хурлын 2024 оны 1 сарын 12-ны 5 тоот тогтоолын хэрэгжилтийн талаар, тэр дотроо зохицуулах хороог мэдээлэл хийх, энэтэй холбоотой албан даалгаврууд хэрэгжилтийн талаар явцын мэдээллийг сонслоо. Тэгээд оператор компаниудтай манайх уулзаж, энэ тогтоолын хэрэгжилт, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал зөвлөлүүд нэлээн ярилцаж байгаа. Тэгээд холбооны дэд бүтцийн асуудал, хөрөнгө оруулалтын асуудлыг яаж багасгах юм бэ? Цаашид давхардсан хөрөнгө оруулалт хийхгүйгээр энэ асуудлыг орон нутагтаа яаж шилжүүлэх вэ гэдэг асуудлуудыг нэлээн бодлогын түвшинд ярилцаж, саналууд солилцож, цаашид хэрэгжүүлэх төлөвлөгөө дээрээ нэлээн ажиллахаар ярилцаж байгаа.

112 дугаартай үйлчилгээг ашиглалтад нэвтрүүлэх асуудал мэдээж олон орон нутгийн иргэдээс ирдэг саналуудын нэг. Юнител болоод Мобиком ч гэдэг юм уу бусад операторын үйлчилгээнүүдийг эзэмшсэн байдаг, манайх том газар нутагтай мэдээж бүх операторууд нэг зэрэг орох боломжгүй энэ газар нутаг дээрээс нөгөө оператор компанийнхаа сүлжээгээр дамжуулаад, яаралтай тусламж, дуудлага авах энэ онцгой нөхцөл байдлын үед олон хүний амь нас эрсдэх нөхцөл байдлыг даван туулах энэ боломжийн талаар чухал асуудлууд хөндөгдөж байгаа. Тэгээд 101, 102 гэдэг энэ 6 дуудлага бүхий дугааруудыг 911 гэдэг. Азидаа 112 гэдэг энэ яаралтай дуудлага, тусламжийн энэ үйлчилгээг нэвтрүүлэх нь иргэдийн болоод манай оператор компаниудын, зохицуулах хороо бид хэд саналаа нэгтгээд, энэ дээр боломжтой, цаашид ойрын хугацаандаа нэвтрүүлээд явах боломжтой гэж үзэж байгаа.

Оператор компаниудын зүгээс яг энэ дэд бүтэцтэй холбоотой хөрөнгө оруулалтыг яаж цаашид багасгах вэ, дэд бүтцийн ашиглалтыг нэмэгдүүлэх тал дээр өөрсдийнхөө байр суурийг өнөөдөр илэрхийлье гэхчхэн байгаа. Тэгэхээр

бизнесийн зарчмаараа нэлээн бие даасан, хараат бусаар хөгжиж ирсэн энэ 5 оператор компани маань өөрсдийнхөө байр суурийг тодорхой илэрхийлэх байгаа.

**Ж.Золжаргал:** Тэгвэл оператор компанийн төлөөллүүд захын 2 микрофон дээр очоод байр сууриа илэрхийлчих үү, 4 минутад багтаагаад. Гараа өргөчхөөрэй. 1 номерын микрофон.

**Ч.Буянтогтох:** Эрхэм гишүүдэд энэ өдрийн мэндийг хүргэе. Мобиком корпорац Буянтогтох. Улсын Их Хурлын Байнгын хорооны Улсын Их Хурлын тогтоолтой холбоотойгоор Цахим хөгжил, харилцаа холбооны яам болон зохицуулах хорооноос операторуудтай 2 удаа ярилцлага уулзалт хийсэн байгаа. Үндэсний роумингийн хэмжээний хүрээнд. Цахим хөгжил, харилцаа холбооны яамнаас бол Олон улсын цахилгаан холбооны байгууллагын зөвлөх үйлчилгээ авсан гэж тэр зөвлөх үйлчилгээ авч байгаа нөхдүүд нь бид нартай ирж уулзсан. Зөвлөхийн гарсан дүгнэлтийг бид нарын хувьд ойлгож байгаагаар бол Монгол Улсад national роуминг хэрэгжүүлэх боломжтой. Тэгэхдээ энэ маань өөрөө арилжааны үндсэн дээр, бусад ихэнх улсад явдаг арилжааны үндсэн дээр явах нь зүйтэй гэсэн дүгнэлт гарсан юм болов уу гэж ойлгож байгаа.

Дээрээс нь 2 дугаарт нь Мэдээлэл холбооны үндэсний ассоциациас судалгаа хийсэн байдаг. Судалгаа дээр бид өнөөдөр байж байгаа үүсээд байгаа асуудлууд, цаашид хэрэгжүүлэхэд ямар асуудлуудыг авч хэлэлцэх үү гэдэг юмнууд дээр тухай бүр байр сууриа илэрхийлсэн. Бүр деталь техникийн асуудлууд руу орох гэхээсээ илүү ерөнхийдөө ер нь цаашдаа хэрэгжүүлэх боломжтой байх. Тэгэхдээ мэдээж хөрөнгө оруулалтууд нэлээн шаардагдана операторуудын хэмжээнд.

2 дугаарт 5G үйлчилгээ орж ирэхээр мөн адилхан асар их хэмжээний хөрөнгө оруулалт шаардана. Манай энэ нөгөө салбарын бизнес маань өөрөө аягүй их хөрөнгө оруулалт, олсон орлогоо эргээд хөрөнгө оруулалтад нэлээн их зарцуулдаг, дэд бүтэц байгуулдаг connectivity үүсгэдэг салбар болохоор иймэрхүү асуудлуудаа бид тухай бүр хэлж байсан. Тусгайлсан дүгнэлт яаж гарсан гэдэг нь одоохондоо бид нарт мэдээлэл байхгүй байна.

3 дугаарт энэ үндэсний роумингтэй холбоотойгоор бид дараа дараагийн технологийн шийдэлтэй холбоотой нэг юмаа харж үзэх ёстой юм болов уу гэж харж байгаа. Өөрөөр хэлбэл сансрын хөдөлгөөнт холбооны бодлого, нам орбитын үйлчилгээ эрхлэгч хэд хэдэн компаниуд дэлхий даяар үйл ажиллагаа явуулж байгаа. Эхнээсээ операторуудтай, зөвхөн Монгол улсад биш, Япон, Европын холбоо ч гэдэг юм уу улс орон даяар сүлжээ хүргэхийн тулд нам орбитын сүлжээг ашиглах замаар, оператортай хамтын ажиллагаа үүсгэх замаар улс орон бүхэлд нь сүлжээ хангах боломжтой байна. Энэ шийдлүүд эхнээсээ боловсорч явж байгаа. Энэ бодлого маань өөрөө Монгол Улсын хэмжээнд цаашдаа яаж явах вэ, энийгээ national роумингтэйгээ яаж уялдуулж харах ёстой вэ гэдэг асуулт байгаа. Энийг маань өөрөө бодлого зохицуулалт яам болон зохицуулах хороо 2 тодорхой хэмжээгээр бодлого гаргана гэж байгаа. Энэ үед авч хэлэлцэж, тайлан мэдээлэл өгөх байх.

**Ж.Золжаргал:** Дараагийн операторын төлөөлөл 2 дугаар микрофон нээж өгье.

**Г.Бат-Эрдэнэ:** Бүгдэд нь энэ өдрийн мэнд хүргэе. Юнител Бат-Эрдэнэ. Би Мобиком корпорацын Буянтогтох захиралтай яг санал нэг байна. Яах вэ нэмээд

хэлэхэд ер нь нэмэлт хөрөнгө оруулалт гэж яриад байгаа нь манай Юнител компани 2006 оноос хойш хөдөө орон нутгийн сүлжээг сайжруулах чиглэлээр нэлээн их сүлжээний хөрөнгө оруулалт хийсэн. Тэгээд хөдөө баг дээр байгаа хөрөнгө оруулалтууд маань дандаа бага оврын тухайн хүн ам бага суурьшсан тэр хэсэгт байдаг учраас бааз станцуудын маань чадал ч гэсэн яг түүндээ таарсан багаар байж байдаг. Хэрвээ national роуминг хийгдээд эхэлбэл энэ хөрөнгө оруулалтууд яг энэ дээрээ нэмэгдэнэ. Манайх өнөөдрийн байдлаар бараг 250, 300 орчим тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт зөвхөн энэ багийн сүлжээ дээр хийчихсэн байдаг маань дахиад энэ дайны хөрөнгө оруулалтууд яригдана.

2 дугаарт роуминг хийж байгаа 2 оператор компанийн дунд Clearing House буюу billing төлбөр тооцооны нэгдсэн Дата төв том бие даасан үйл ажиллагаа явуулах байгууллага байх ёстой болдог. Тэгээд тэр байгууллага маань одоогоор Монголд яг ийм байгууллага байхгүй. Мэдээж ямар нэгэн байгууллага байгуулагдаад, энэ бодлогын дагуу хийгдээд явлаа гэхэд бизнесийн арилжааны зарчмаар нөгөө байгууллага маань дундаас нь өөрсдийнхөө ашиг, бизнесийн ашгийг хүртэх ёстой болно. Тэгэхээр ер нь эцсийн хэрэглэгч дээр очих төлбөр маань багаар бодоход 3 дахин ер нь өсөхөөр. Угаасаа олон улсын роуминг яг дотооддоо ярьж байгаагаас яагаад үнэтэй байдгийн шалтгаан бол ерөөсөө энэ байдаг. Мэдээж 2 оператор компани өөрсдийн бизнесийн ашиг, дундын Clearing House, тэрний хөрөнгө оруулалт, эргээд нөхөх гээд энэ бизнесийн зарчмаараа явдаг учраас өндөр хөрөнгө оруулалттай байдаг.

**Ж.Золжаргал:** 1 номерын микрофон нээж өгье.

**Я.Батжаргал:** Та бүхэнд өдрийн мэнд хүргэе. Скайтел компани Батжаргал Технологийн газрын захирал. Ер нь өмнөх операторууд нэлээн дэлгэрэнгүй тайлбар хэлчихлээ. Гэхдээ онцлоод дахиад нэмээд хэлэхэд Скайтел компанийн хувьд 2G систем нь стандартын хувьд G... бүлээс өөр учраас Үндэсний роуминг дээр түүн дээр 2G, 3G хооронд шууд хийхэд бэлэн гэж ойлгоход буруу болж байгаа юм. Түүн дээр тайлбар нэмэлт хэлье.

2 дугаарт үндэсний роуминг саяын тэр яаралтай тусламжийн дугаарууд гээд энэ дээр бүх талаар хамтран ажиллаж байгаа, тестүүд амжилттай болсон. Гэхдээ энэ нөгөө яаралтай тусламжийн кэйс бол төлбөргүй байдаг учраас энэ ингээд зөвхөн үндсэн нэг систем дээр ингээд харилцан холболт хийгээд болчхож байна. Зүгээр яг үндэсний роуминг хийгээд, бүтээгдэхүүн болгоод төлбөр тооцоотой явъя гэвэл энэ нэмэлтээр төлбөр тооцооны систем ингээд хэрэглэгчийн мэдээлэл, бусад системүүд дээр нэмэлт хөгжүүлэлт хийгдэх учраас энэ дахиад цаг хугацаа авсан ийм ажил болох болов уу гэж бодож байна. Дэд бүтцийн хувьд ер нь бизнесийнхээ зарчмаар техникийн боломжтой тохиолдолд бид харилцан хуваалцах энэ share хийх зарчмаа баримтлаад явж байгаа.

**Ж.Золжаргал:** Өөр саналаа хэлэх оператор? 2 номер.

**Б.Мандуул:** Та бүхний өдрийн амгаланг эрье. Ондо компани ямар байр суурьтай байгаагаа илэрхийлье. 1 дүгээрт давхардсан хөрөнгө оруулалт байгаа гэдгийг энд байгаа бүх хүмүүс ойлгодог байх. Тэгээд давхардсан хөрөнгө оруулалт хэн ашиг хийдэг вэ гэхээр манай урд хөрш ашгаа хийдэг. Тэгээд манай газар нутгийн 26 хувь нь дэд бүтцэд холбогдсон байдаг. Нийт хүн амынхаа 97, 8 хувийг бид харилцаа холбоонд холбочихсон байгаа. Гэхдээ хэдүүлээ зарчмын хувьд ер нь



роуминг хийснээр дэд бүтэц тэлчихсэн компаниуд илүү ашиг хийнэ гэдгээ ойлгох хэрэгтэй.

Нэг зүйл нь харилцаа холбооны салбарын технологийн шийдэл нь хувьсаад саяын яриад байгаа өндөр өртгөөр бий болно гээд байгаа зүйл чинь маш бага зардлаар бий болох боломжууд нь бий болчихсон байгаа. Тэгэхээр энийг судалж үзээд, яг тоогоо харж байгаад шийдэх нь зүйтэй гэж хэлмээр байна. Яг хөдөө орон нутагт явж байгаа саяын орон нутагт байгаа хүн амын тоон дээр суурилсан дэд бүтэц байгуулчихсан тохиолдолд бусад операторын хэрэглэгч ороод ирэхээр тэнд даац хэтэрнэ гэдэг тооцоолол байгаа бол энийг бататгах тоо хэрэгтэй. Энэ бол таамаг байх гэж би хэлмээр байна.

Хэдэн удаа алслагдсан сум руу хотоос олон хүн очдог юм бэ? Тэгээд саяын дэд бүтцийн даац хэтэрнэ гэж хэлсэн операторууд дээр ямар тоон мэдээлэл байгааг бид өнөөдөр сонсмоор байна. Тэгээд саяын роуминг хийснээр хүн амын урсгал ямар хурдацтайгаар явдаг тэрийг даах хэмжээний дэд бүтэц хаана, хаана байхгүй байгаа юм бэ? Эцсийн дүндээ Монгол хэрэглэгч, Монгол хүн өөрөө харилцаа холбооны үйлчилгээ авах уу, үгүй юү гэдгийг бид одоо шийдэж байгаа бол хүндээ өөрт нь шийдэх боломжийг нь өгөөд, харилцан холболтыг нь хийж өгөөд, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүнээ авах уу, үгүй юү гэдгийг нь зах зээлийн зарчмаар шийдэх энэ боломжийг нь үлдээх ёстой гэж манай компани үздэг.

Нөгөө талдаа энэ салбар өөрөө хамгаалагдчихсан салбар. Тусгай зохицуулалттай. Хөрөнгө оруулалт хийлээ гэж яриад байгаа бол энэ угаасаа та хөрөнгө оруулалт хийнэ, тэрнийхээ өгөөжийг авна гээд анх лиценз авахад чинь л энэ бизнесийн тоглоомын дүрэм нь тодорхой байсан. Тэгэхээр энэ хамгаалагдчихсан зохицуулалттай энэ салбарт бизнес хийж байгаа бол 1 дүгээрт мэдээж тоон үзүүлэлтүүдээ хардаг байх, 2 дугаарт үйлчилгээ чинь орон даяар Монгол хүн болгонд ашигтай, хөрөнгө оруулагчдаа ер нь харилцан ашигтай тэр цэг дээр л очих ёстой байх гэж бид хардаг. Тэгэхээр яах вэ харилцаа холбооны салбарт байгаа технологийн өнөө цагийн шийдлүүдийг харах, тусгаар тогтносон улс юм бол яг өөрсдөө энийгээ шийдэх тэр цэг рүү л явмаар байгаа юм.

**Ж.Золжаргал:** Өөр энэ хувийн хэвшлээс, операторуудаас төлөөлж үг хэлэх хүн байна уу? Жи-Мобайл 1 дүгээр микрофон нээж өгнө үү.

**А.Энх-Амгалан:** Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Жи-Мобайл компанийн захирал Энх-Амгалан. Үндэсний роуминг явуулснаар сая операторууд маань бүгд тайлбаруудаа бараг дийлэнхийг нь хэлчихлээ. Давхардсан юугаар дахиж хэлээд яах вэ. Тэгэхээр зүгээр энэ миний зүгээр харж байгаагаар манай компанийн харж байгаагаар зүгээр том операторуудын хөрөнгө оруулалтын дарамт жижиг операторуудад роуминг үйлчилгээний тарифын дарамт гэсэн 2 юмнууд л асуудал болох байх. Энэ дээр хэрхэн зохицуулалтаа хийх байдлаасаа хамаараад Монгол Улсад энэ юуг хэрэгжүүлэхэд бүрэн боломжтой байх гэж бодож байна.

**Ж.Золжаргал:** 2 дугаар микрофон.

**У.Тамир:** Мэдээлэл холбооны операторуудын ассоциацийн гүйцэтгэх захирал Тамир байна. Би яах вэ нэг манайхан бүгд угаасаа ярьчихлаа. Тэгээд товч хийхэд энэ засгийн, Их Хурлын тогтоолыг хэрэгжүүлэхийн тулд Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамнаас 2 судалгаа өнгөрсөн онуудад хийсэн. Нэг нь дотоодын мэргэжилтнүүдээр хийлгэсэн. 2 дахь нь болохоор олон улсын цахилгаан

холбооны байгууллагаас хийлгэсэн ийм 2 судалгааны дүнг бидэнд танилцуулсан. Тэгээд тэр судалгааны дүнгээс жишээлээд өөрийнхөө хүмүүсийн ярьсан юман дээр нэмээд нэг хэдэн юм хэлчихье гэж бодож байна.

Тэгээд тэр судалгаа дээр харахаар ихэнхдээ national роуминг үйлчилгээг нөгөө эхнээсээ бүсчилсэн байдлаар тусгай зөвшөөрлийг нь олгочихсон улс орнууд илүүтэй хэрэгжүүлдэг. Манай орны хувьд онцлогтой. Эхнээсээ бүх операторууддаа Монгол Улсын нутаг дэвсгэрт гэдэг үүрэг хүлээлгэсэн лиценз олгочихсон учраас өнөөдөр хүмүүс ингээд харахаар давхардчихсан хөрөнгө оруулалт хийгээд, бүгдээрээ хийгээд байгаа юм шиг байдлаар ингэж ихэнхдээ нөгөө талаасаа харагддаг. Гэхдээ энэ маань бид нарын анхнаасаа тусгай зөвшөөрлөөр авчихсан хүлээсэн үүрэг юм. Тэгэхээр ийм утгаараа харахаар одоогийн байдлаар нэг хүн амынхаа бараг 99 хувьд нь хүргэчихээд байгаа, цаана нь үлдэж байгаа 1 хувь бол үлдэж байгаа. Дээр нь магадгүй нөгөө ингээд хөдөлгөөн хийгээд явж байгаа хүмүүс хэд байх вэ гэсэн ийм нарийн судалгаа гараагүй байгаа.

Тэгэхээр үндэсний роуминг хийхэд түрүүн Clearing House-н асуудал, хөрөнгө оруулалтын асуудал яриад байгаа нь Clearing House чинь өөрөө тодорхой хэмжээний хөрөнгө оруулалт хийгдэнэ. Тэр найдвартай бүх системийг яг бид нарын явуулж байгаа шиг аюулгүй байдлыг хангасан найдвартай, тасралтгүй системийг бий болгох тийм чадвартай компани жишээлбэл тэрийг хийх ёстой. Тэр нь тэгэхээр бас мэдээж тодорхой хэмжээний нэлээн өндөр хөрөнгө оруулалт шаардагдана. Дээр нь оператор болгон тэр Clearing House-тай холбогдохын тулд өөрсдийн программ хангамж, bill-н систем бүх юмандаа өөрчлөлт хийнэ. Бид нарын тооцоолж байгаагаар 1 компаниас гэхэд дор хаяхад 20 сая ам.доллар гарах байдалтай харагдаад байгаа.

Тэгээд эцэстээ харахаар хэрэглэгчийн өртөг, Clearing House өртөг, нэмээд энд холбогдох өртгүүдээ тооцоод үзэхээр буцаад хэдий хэмжээний хэрэглэгч шилжих юм бэ гэдэг тоо. Тэрний 99 хувиас чинь хэд нь аваад, үлдсэн 1 нь хэд болох вэ? Тэгэхээр ийм хэмжээний хэрэглэгчид ийм хэмжээний хөрөнгө оруулалт хийх нь өөрөө үр ашиггүй байгаа юм гэж ингэж үзээд энэ нь бизнесийнхээ зарчмаар операторууд өөрсдөө бизнес, хөрөнгө оруулалтаа тооцоод ингээд хоорондоо арилжааны зарчмаараа хэлэлцээд share-ээ бараг i... дахь share-ээ ашиглаад явах нь илүүтэй юм гэж харж байгаа.

Нөгөө талдаа манай салбарын хувьд бүрэн либералчлагдсан, ингээд хувийн хэвшил дээр явдаг. Дээр нь хөрөнгө оруулалтын өгөөж маш урт байдаг. Технологи яагаад гэвэл өөрөө маш хурдан өөрчлөгддөг учраас бид 4G гэхэд 2016 онд оруулсан бол одоо ингээд 5G оруулах гээд явж байна. Тэгээд энэ өндөр хөрөнгө оруулалтыг нөхөх хугацаа чинь өөрөө урт байдаг учраас ийм үр ашиггүй хөрөнгө оруулалт оруулах нь, тэгээд ийм үр ашиггүй байна. Энэний оронд магадгүй тэр гамшгийн үед нөгөө тусгай дугаарт шууд холбогддог аргаа ашигласан нь илүүтэй дээр юм болов уу гэж үзэж шийдвэрлэсэн гэж үзэж байгаа юм. Энийг нэмж хэлэх гэсэн юм.

Дээр нь яах вэ бүтэн либерал салбарын хувьд хэрэглэгчдийн үнэ тариф өөрөө аягүй эмзэг байдаг. Бид чинь өөрсдөө ингээд битүү ингээд бүтэн өрсөлдөөнтэй учраас үнээ буулгаж чаддаггүй. Үнэ жоохон өсөхөд л маш эмзэг хэрэглэгчтэй. Тэгэхээр магадгүй 3 дахин өртөгтэй тэр үнийг маань авах хэрэглэгч хэд байх вэ гэдэг тоо тодорхойгүй байгаа учраас ийм хэмжээний эрсдэл үүрч хөрөнгө оруулалт хийх нь бид нарт үр ашиггүй байна гэж харж ингэж энэ саналаа

бид Цахим яам, Харилцаа холбооны яамныхан, Зохицуулах хорооныхонд илэрхийлээд явж байгаа. Баярлалаа.

**Ж.Золжаргал:** Баярлалаа. Энэ улсын бодлого иргэдэд яаж үр ашигтай үйлчилгээг хүргэх вэ гэдэг чиг зорилгоор л гарч байгаа шүү дээ. Тэгэхээр нэг талаасаа харилцаа холбооны компаниуд гэдэг бол өөрөө ард түмний хэсэг. Бизнес явуулж байгаа тэдний эрх ашгийг тооцох шаардлагатай. Нөгөө талдаа иргэдийн энэ хөдөлгөөнтэй холбоотой, холбоо харилцаандаа хаана ч байсан холбоотой байя гэдэг нь бодитой хэрэгцээ шаардлага. Миний ойлгож байгаагаар энэ тогтоол гарахдаа яг та бүхний ярьж байсан энэ асуудлыг сонсож л байсан байх. Бүх талаас нь сонсож байгаад ийм шийдвэр гарсан гэж бодож байна. Тэгэхээр яах вэ ингээд нэг талдаа хүндрэл байна, нөгөө талдаа хэрэгцээ байна. Яг хэдэн төгрөгийн, ямар хөрөнгө оруулалт ороод, яагаад болохгүй байгаад байгаа гэдэг ийм тайлан энэ тогтоолын хариу болгож гараагүй юм байна гэж ойлгосон.

Тэгэхээр энийг бид гаргах шаардлагатай. Үнэхээр саяын хийж байгаа тайлбарууд дээр мэдээж энэ бол бизнесийн салбар, арилжааны зарчимд тулгуурлах ёстой. Тэгээд арилжааны зарчимдаа тулгуурлаад нөгөө роумингийг нь хэрэглэж байгаа хүмүүс нь илүү мөнгө төлж таарна. Үгүй бол яах вэ өөрийнхөө оператораар л явна. Тэгэхдээ боломж нь нээлттэй байх ёстой гэж. Энэ ингээд хэрэгжих боломжгүй, ашиггүй гэж байгаа ийм дүгнэлт байгаа бол тэрийгээ маш тодорхой тавиад, бодлогын өөрчлөлт оруулах асуудлыг бидэнд тавих хэрэгтэй. Хэрвээ энэ бодлого буруу байна, тогтоол буруу гарсан юм байна гэж дүгнэж байгаа бол тэрийгээ ил тод хэлээд, хэлэлцээд явах хэрэгтэй гэж бодож байна.

Асуулт, хариултдаа оръё. Хэлэлцэж байгаа асуудалтай холбоотой асуулт тавих бол нэрээ өгнө үү гишүүдээ. Нэрээ өгчихсөн байна. Ундрам гишүүн, Цэнгүүн гишүүн асуулт асууна. Ундрам гишүүний микрофоныг нээж өгье.

**Ч.Ундрам:** Манай харилцаа холбооны салбар яах вэ харьцангуй ингээд л либерал байдлаар нэлээн өөрийнхөө хэмжээнд хөгжөөд явж байгаа салбар гэж би хардаг л даа. Уул уурхай, санхүүгийн салбарын дараа л орж байгаа шүү дээ. Татвар төлөлтийн хэмжээ, хөрөнгө оруулалт. Гэхдээ нөгөө талаас мэдээж улс орны аюулгүй байдалтай холбоотой ийм асуудал байх. Тэгээд энэ Их Хурлын 5 дугаар тогтоол нь энэ надад тараагдсан материал дээр 2024 он гээд гарчиг дээр нь байгаа мөртөө дотор нь 2020 онд гарсан гээд байж байна л даа. Энэ яг хэзээ гарсан гэдгийг яг тодруулаад өгөөч? Тэгээд тухайн үед энэ давхардсан хөрөнгө оруулалт их байна энийгээ зохицуулах хэрэгтэй, роумингтэй болох хэрэгтэй эд нар гээд, дугаараа аваад шилждэг болох ёстой гээд энэ агуулгуудыг оруулахдаа нэлээн их судалгаа, хэлэлцүүлэг байсан байж таараа гэж би бодоод байна л даа. Тэр үед яг гарсан үндэслэлүүдийг нь бид харж байж өнөөдөр нэлээн тодорхой асуулт тавьж, тодорхой шийдэл гаргана гэж би бодоод байна.

Гэхдээ өнөөдрийг хүртэл ямар ч байсан энэ салбар ингээд өөрийнхөө хэмжээгээр хөгжөөд өдий зэрэгтээ хүрчихсэн байхад нь төр ингээд хамаагүй ороод хутгалдаад байх нь зөв үү, үгүй юү? Энэ дээр нэлээн болгоомжтой хандах ёстой. Манай энэ Харилцаа холбооны зохицуулах хороо бол яг өөрийнхөө хэмжээнд маш сайн бодлогоо аваад ажиллаж байгаа гэж би бодож байна. Тэгэхээр нэлээн судалгаатай өмнө нь юу яригдаж байсан юм, одоо яг нөхцөл байдал юу байгаа юм бэ гэдгийг бид сонсож байж, мэдэж байж дараагийн юмнуудыг ярихгүй бол энэ чинь технологийн асуудал. Бид шууд ингээд л янз бүрийн мэргэжилтэй улс төрчид орж ирээд л дураараа юм яриад байж болохгүй гэж бодож байна.

Тэгээд энэ 112 дугаарыг тоот дугаар нэвтрүүлж байна гэж байна шүү дээ. Энэ бол үнэхээр хэрэгтэй. Энэ хэмжээндээ ер нь явахад яасан юм бэ гэсэн би дотроо бодолтой байна. Энэ дугаараа аваад шилждэг болох гээд компани хооронд гэж байна шүү дээ. Энэ асуудал ер нь боломжтой юм уу, үгүй юү гэдэг нэг асуулт байна. Японд бол тэгдэг шүү дээ. Дугаараа аваад л өөр өрсөлдөөнийг нь харж байгаад л, үнэ тарифыг нь харж байгаад нөгөө компани руу шилждэг. Ийшээ шилжих ер нь боломж байгаа юм уу, компаниуд нь өөрсдөө юу гэж бодож байгаа юм бэ гэдгийг мэдмээр байна.

Тэгээд энэ Бүх нийтийн үүргийн сан бол нэлээн сайн үүргээ гүйцэтгэж байгаа, энэ аягүй зөв бодлого гэж би бодоод байгаа. Багуудад хөрөнгө оруулалтууд хийгдэж байна. Харин энэ давхардсан хөрөнгө оруулалт байдаг бол энийг багасгах тал дээр дахиад дорвитой ажлууд илүү хийгдээсэй гэсэн ийм л асуулт болон хэдэн санал байна даа.

**Ж.Золжаргал:** Баярлалаа. 3 номер, 3 дугаар микрофон хариулт өгнө.

**А.Лувсан-Очир:** ХХЗХ Лувсан-Очир. Ундррам гишүүний асуултад хариулъя. Эхний асуулт энэ 2024 оны 5 дугаар тогтоол танилцуулгад ингээд 2020 оны магадгүй 2013 оны ЗГ-ын тогтоолууд ингээд орчихсон байна гэдэг. Тэгэхээр энэ талаар тайлбар өгөөч гэж асуулаа гэж ойлгосон. Тэгэхээр энэ сүлжээний давхардсан хөрөнгө оруулалт, сүлжээний дэд бүтэц ашиглахтай холбоотой, ашиглалтыг сайжруулахтай холбоотой асуудал зөвхөн 2024 онд босож ирж байгаа асуудал биш. Өөрөөр хэлбэл 2013 он, 13 оноос өмнө, 13 оноос хойших, тэгээд 24 оны 5 дугаар Улсын Их Хурлын 5 дугаар тогтоол гээд энэ бүх шийдвэрүүд хоорондоо хамааралтай байгаа юм.

2013 оны ЗГ-ын тогтоолоор үндсэн сүлжээ дээр давхардсан хөрөнгө оруулалт хийхгүй байх, сүлжээг илүү хүртээмжтэй болгох. Хүртээмж гэдэг ойлголт Монгол Улс өөрөө хүн ам сийрэг, газар нутаг өргөн учраас бүх сум, суурин газруудаа үндсэн сүлжээнд холбох энэ зорилгын хүрээнд давхацсан буюу ашигтай цэгүүд рүү хөрөнгө оруулалт хийхээсээ илүү нийт газар нутгийнхаа сүлжээнд холбогдох гэдэг энэ зорилт тавьж ингээд хэрэгжсэн. Ингээд шийдвэрүүдийн уялдаа холбоо, залгамж чанар холбогдож явж байгаад 2024 оны Улсын Их Хурлын 5 дугаар тогтоолтой уялдаж байгаа юм гэдгийг тайлбарлая. Тэр утгаараа түүхийн шатлалыг танилцуулгад дурдаж өгсөн.

112-той холбоотойгоор Ундррам гишүүний санал дэмжиж байгаа санал гэж ойлголоо.

3 дугаарт нь дугаартайгаа шилжих үйлчилгээтэй холбоотой асуудал хуульд туссан байна. Энэний хэрэгжилтийн асуудал дээр ямар нөхцөл байдал байна вэ гэж байна. Түрүүн Золжаргал дарга тайлбартаа хэлсэн. Бид Цахим хөгжил, харилцаа холбооны яам хуучин нэрээр 2023 онд Харилцаа холбооны тухай хуулийн хэрэгжилтийн үр нөлөөний дүн шинжилгээ хийсэн байгаа. Энэ дүн шинжилгээний хүрээнд энэ дугаартайгаа шилжих үйлчилгээ яг нэвтрэх бололцоотой юм уу, энэ хуульд энэ зохицуулалт нь байх шаардлагатай юм уу, үгүй юү гэдэг дүн шинжилгээ хийсэн. Тэгэхээр хуулийн хэрэгжилтийн дүн шинжилгээний хүрээнд хуулийн 3 дугаар зүйл дээр байгаа нэр томьёо, 9 дүгээр зүйл буюу Зохицуулах хорооны бүрэн эрх дээр байгаа чиг үүрэг, 25 дээр байгаа, 25.2 дээр байгаа үйлчилгээ эрхлэгчдэд үүрэгжүүлсэн энэ 3 заалт бол хуулийн хэрэгжилтийн үр дүнгийн үнэлгээний хүрээнд

бол одоо хэрэгжих боломжгүй байна. Өөрөөр хэлбэл хуульд нэмэлт, өөрчлөлт орвол уг заалтыг хүчингүй болгох шаардлагатай байна гэсэн ийм дүгнэлт үнэлгээний явцад гарсан байгаа. Хариулж дууслаа.

**Ж.Золжаргал:** Ундрам гишүүн хариулт хангалттай юу, нэмэлт? Ундрам гишүүний микрофон нээж өгье тодотгол.

**Ч.Ундрам:** Энэ дугаараа аваад шилжих асуудал яг ямар учраас боломжгүй гэсэн ийм дүгнэлт гарсан юм бэ? Яг ийм тодорхой шалтгаанууд хэлээд өгөөч?

**Ж.Золжаргал:** 3 дугаар микрофон нээж өгье.

**А.Лувсан-Очир:** Тэгээд дугаартайгаа шилжих үйлчилгээ Харилцаа холбооны тухай хуульд 2024 оны биш ээ, 2014 оны 7 дугаар сард нэмэлтээр орж ирсэн. Харилцаа холбооны зохицуулах хороо дугаартаа шилжих үйлчилгээний хуулийн заалтыг хэрэгжүүлэхтэй холбоотой 2014-өөс 2016, 2016-аас 2018 онуудад шат дараалсан арга хэмжээ авсан. 1 дүгээрт дугаартайгаа шилжих үйлчилгээг хэрэгжүүлэхтэй холбоотой үйлчилгээ эрхлэгч талуудын төлөөллийг оролцсон ажлын хэсэг зохион байгуулж, хэрэгжүүлэх технологийн 4 шийдэл гаргасан. Нэг нь дундын төв байгуулах буюу Clearing House байгуулж, дугаартайгаа шилжих үйлчилгээг нэвтрүүлэх. Энэтэй холбоотойгоор 2014 оны ханшаар 35 тэрбум төгрөг буюу 10 орчим сая долларын хөрөнгө оруулалт нэмэлт шаардлагатай байна. Энэ бол оператор тус бүр дээр. Тэгэхдээ операторуудын шийдлээс хамаараад хөрөнгө оруулалтын ялгаатай хэмжээ байсан. 2 дугаар хувилбар нь аль нэгэн оператор компани энийг хариуцаад явах шийдэл. 3 дугаар.../минут дуусав/

**Ж.Золжаргал:** 3 дугаар микрофон нэмэлт цаг өгье.

**А.Лувсан-Очир:** 3 дугаар хувилбар нь энэ дугаартайгаа шилжих үйлчилгээг ямар нэгэн байдлаар тусгай зөвшөөрөл олгож, тусгай зөвшөөрлийн хүрээнд эрхлүүлэх. Өөрөөр хэлбэл Зохицуулах хороо үйлчилгээ эрхлэгч гуравдагч этгээд болох хөндлөнгийн компанид тусгай зөвшөөрөл олгох зарчмаар. 4 дэх хувилбар нь ХХЗХ өөрөө хөрөнгө оруулалт хийж, clearing house буюу дундын холболтын төвийг байгуулах гээд. Энэ болгон дээр тус бүр дээр нь судалгаа, дүн шинжилгээ хийгдсэн байдаг. Улсын Их Хуралд 2016-аас 2020 оны Улсын Их Хурлын бүрэн эрх нь хэрэгжсэн Улсын Их Хуралд энэ дугаартайгаа шилжих үйлчилгээний энэ тайлан мэдээллийг дэлгэрэнгүйгээр нь хүргүүлж байсан. Саяын 4 технологийн шийдлийг хэрхэн хэрэгжүүлсэн, хэрэгжүүлэх бололцоо байсан, ямар хүндрэл учирч байсан талаарх дэлгэрэнгүй мэдээллийг хүргүүлж байсан. Энийг нь ярих юм бол нэлээн цаг гарна. Хэрвээ шаардлагатай гэвэл ХХЗХ-ноос тайланг албан бичгээр хүргүүлж болно.

**Ж.Золжаргал:** Тайланг албан бичгээр хүсэлт явуулж авна. Цэнгүүн гишүүний асуултыг сонсьё, микрофон нээж өгнө үү.

**С.Цэнгүүн:** Тэгэхээр өнөөдөр бид маш чухал асуудлын талаар ярьж байна л даа 5G технологи ярьж байхад энд ингээд гарах хүндрэлүүд гээд тэгсэн чинь хэрэглэгчийн гар утас төхөөрөмж бэлэн байдал хангалтгүй гэх мэт ийм шалтаг тоочоод сууж байж бид үнэхээр болохгүй. Манай Монгол Улсын хүн ам залуучууд байгаа. Тэгээд дэлхий ертөнц маань хаашаа явж байна гэдгийг та бүхэн надаар хэлүүлэлгүй мэдэж байгаа. Бид цахим орчинд амьдарч байна. VR, AI гээд энэ бүх clouds, computing энэ тэр гээд бүх энэ нөгөө нэг технологийн дэвшил ирээдүй маань

5G технологи дээр байгаа. Тэгэхээр бид энэ 5G рүү шилжих шилжилтээ аль болох яаралтай хурдтай хиймээр байна. Манай залуучууд бүгдээрээ esport дээр дэлхийд танигдаад гараад ирж чадаж байна шүү дээ. Тэгж байхад чинь бид манай улсад 5G байхгүй гээд сууж байгаа байхгүй юу. Тэгэхээр бид энэ 5G-ийн тухай асуудлаа яаралтай шийдэх ёстой. Цахим үндэстэн болно гээд энд 24-өөс 28 оны төлөвлөгөө дээрээ хүртэл оруулаад явчихсан байж энэ талаар хэлэлцээд сууж байгаа бол утгагүй санагдаад байна л даа.

Тэгээд энэ 5 дугаар тогтоолтой холбоотой нэг харагдаж байгаа юм нь 112 гээд дугаар зайлшгүй хийх ёстой, өдөр хоног алдаж боломгүй яаралтай хийх шилжилтээ бид гаргах ёстой байгаа юм. Тэгээд сая мэргэжилтнүүдийн яриаг ингээд сонсоод байж байхаар хэн хэрэгжүүлэх нь жоохон тодорхойгүй үлдчихсэн юм болов уу гэж ойлгогдоод байна. Тэгэхээр энэ Цахим хөгжлийн яаман дээрээ яг хариуцаад, энийгээ ажиллаад явчхаж болохгүй байгаа юм уу? Энэ ажлаа түргэвчлээд хийчхэж болохгүй юм уу? Тэгэхгүй бол ингээд яг хэн хариуцаж энийг яг ажиллагаанд оруулах нь мэдэгдэхгүйгээс болоод гацчихсан юм шиг санагдаад байна. Яагаад гэхээр операторууд нь ч нэг санал дээр ирчихсэн байгаа юм байна. Харилцаа холбооны зохицуулах хороо ч гэсэн нэг нэгдсэн шийдэлд хүрчихсэн байгаа юм байна шүү дээ. Тэгэхээр магадгүй манай Инновац, цахим байнгын хорооноос тогтоол гаргаад ч байдаг юм уу бид энийг хурдтай, яаравчлан шийдэх боломжоор нь хангаад өгчих хэрэгтэй юм шиг санагдаж байна л даа.

Тэгээд нэг зүйлийг асуумаар байгаа юм. Сая энэ 24 оны 2 сард өргөн бариад, тэгээд батлагдаагүй байгаа энэ Харилцаа холбооны тухай нөгөө нэг хууль байна шүү дээ, нэмэлт, өөрчлөлт. Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай гээд. Тэгээд энэ өөрөө буцаагдчихсан байгаа юм байна. Тэгээд энэ дээр уг нь бол маш зүйтэй шинэчлэлүүдийг хийх байсан. Улс төрийн оролцоог нь багасгах, хараат бус байдлыг өөрчлөх гээд. Тэгээд энэ ер нь яагаад буцаагдчихсан байгаа юм бол? Энэ дээр ямар асуудал үүссэн юм бол гэдгийг асууя.

**Ж.Золжаргал:** Цэнгүүн гишүүний 3 асуултад тодорхой хариулт өгнө үү. 6 дугаар микрофон нээж өгье. Тулгат зөвлөх.

**М.Тулгат:** Та бүхэнд мэнд хүргэе. Сайдын зөвлөх Тулгат. Харилцаа холбооны тухай хуулийн үзэл баримтлал буцаагдсан. Тэгээд үүнтэй холбоотойгоор хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөл 8 зүйлээр буцаагдаж, 8 засвар орох шаардлагатай гэсэн ийм үндэслэлээр буцаагдсан. Энэ дээр тус яам болон ХХЗХ хамтран ажиллаад, үзэл баримтлалын төсөл дээр засвар оруулаад ингээд явж байгаа. Ажлын хэсэг гаргачихсан явж байгаа. Тэгээд энэ дээр манай зохицуулах хорооны зүгээс нэг хэд хэдэн 4 заалт дээр яаралтай хариугаа өгмөөр байна. Танайхаас хүлээгдэж байгаа зүйлүүд байгаа шүү дээ. Яах вэ энийг бид салбар дотроо асуудлаа шийдээд явчихна. Тэгээд ерөнхийдөө сая хуулийн төсөлд нэмэлт, өөрчлөлт оруулах ажлын хэсэг шинээр байгуулагдаад, ингээд ажилдаа ороод явж байгаа гэдгийг та бүхэндээ мэдээлэл болгож өгье. Бид энэ асуудлыг шуурхайлаад явна гэдгийг хэлэх байна. Баярлалаа.

**Ж.Золжаргал:** Харилцаа холбооны зохицуулах хорооны зүгээс 5G маань яагаад нэвтрэхгүй удаашраад байна вэ? Энэ тал дээр мэдээлэл өгнө үү. 3 дугаар микрофон нээж өгье.

**А.Лувсан-Очир:** Гишүүний асуултад хариулъя. 1 дүгээр асуулт буюу 5G технологи нэвтрүүлэхтэй холбоотойгоор. 5G технологийг нэвтрүүлэхтэй

холбоотойгоор ердөө шүүхийн маргаантай холбоотой л асуудал байгаа 5G технологийн радио давтамжийн зурвасыг хуваарилах асуудал дээр тодорхой зурвас буюу 3700-аас 3800 мегагерцийн зурвас дээр шүүхийн шатны маргаан үүссэн. Яагаад шүүхийн шатны маргаан үүссэн байгаа нь 5G технологи буюу тусгай зөвшөөрлийг олгох боломжгүй байна вэ гэхээр Радио долгионы тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.7 дээр эрхийн бичиг болон тусгай зөвшөөрлөөр олгогдсон радио давтамжийн зурвас нь шүүхийн маргаантай бол уг зурваст, радио долгионы зурвас дээр тусгай зөвшөөрөл олгохыг хориглочихсон байдаг. Тэгэхээр ингээд шүүхийн маргаантай асуудал явагдаж байгаа.

Шүүхийн шүүхийн маргааны явц нь захиргааны хэргийн давж заалдах шатын шүүхээр шийдвэрлэгдчихсэн байж байгаа. Мэдээж нөгөө тал хяналтын шатаар Улсын дээд шүүхэд гомдол гаргах эрх нь нээлттэй байж байгаа. Ингээд 3 шатын шүүхийн шийдвэрийн асуудал явагдсаны дараа бол 5G-н энэ тусгай зөвшөөрөл бол олгогдох ийм бололцоо бүрэн нээгдэнэ. Яагаад энэ шүүхийн шийдвэрийг, шүүхийн шийдвэрийн маргаантай байгаа зурвасыг орхиод бусад зурвас дээр тусгай зөвшөөрөл олгож болохгүй юм бэ гэхээр радио давтамж өөрөө өрсөлдөөнд хамгийн чухал нөлөөтэй нэг хүчин зүйл мөн. Тэгэхээр Харилцаа холбооны зохицуулах хорооны өөрийн хуулийн чиг үүрэг бол зах зээлд өмчийн бүх хэлбэрийн ААН-ийг шударга өрсөлдөх нөхцөлийг л бүрдүүлэх зохицуулалттай, 8.1 дүгээр зүйлээр Харилцаа холбооны тухай хуулиар.

Тэгэхээр тэр чиг үүргийнхээ хүрээнд бид энэ шүүхийн маргааныг эцэслэсний дараа бол 5G-н тусгай зөвшөөрлийг олгох ийм бололцоо байгаа. ХХЗХ-ноос 5G технологийг нэвтрүүлэхтэй холбоотойгоор 2021 оноос эхлэн үйлчилгээ эрхлэгч 5 оператор компанид түр зөвшөөрлийг олгоод явж байгаа. Яг энэ цаг хугацаанд 5 оператор компаниас 3 оператор компани нь 5G үйлчилгээг нэвтрүүлэхтэй холбоотой түр зөвшөөрөл ашиглаад, туршилтын ажлаа хийгээд, тайлан мэдээллээ ХХЗХ-нд ирүүлж ажиллаж байгаа.

**Ж.Золжаргал:** Энэ дээр холбоотой операторуудаас хэлэх үг байгаа юу? Байхгүй юм байна гэж ойлголоо. Цэнгүүн гишүүн та хариултаа авч чадав уу, нэмж тодруулах зүйл байна уу? 112, 5 дугаар микрофон нээж өгье.

**П.Алтан-Од:** Цэнгүүн гишүүний асуултад хариулъя нэмэлтээр. Ер нь Монгол Улс 325 сум 21 аймгаа шилэн кабельд холбосон. Бид ирэх жил 5 сумыг шилэн кабельтай холбох, 3 боомтыг холбох энэ зорилт тавьж ажиллаж байна. Мөн Улсын Их Хурлын гишүүд, холбогдох орон нутгийн иргэдийн Хурал, Засаг даргаас ирсэн хүсэлтээр 196 баг буюу суурин газарт харилцаа холбооны сүлжээ оруулж өгөх хүсэлт одоогоор ирсэн байгаа. Энэ цаашид ингээд нэмэгдэх ийм хандлагатай байгаа.

Тэгээд 112 дугаарын асуудлыг салбар дундын зохицуулалт шаардсан мэдээж харилцаа байгаа. Шадар сайдын асуудал байна, Хууль зүйн сайдын асуудал хамаарах асуудалд, асуудалд хамаарах асуудлууд байна. Дээр нь Цахим, харилцаа холбооны асуудал, Эрүүл мэндийн яамны асуудал гээд ингээд салбар дундын зохицуулалт шаардсан асуудлыг Цэнгүүн гишүүн нэлээн соргоогоор харж. Ер нь цахим хөгжил энэ цаашид инновацын асуудал, хиймэл оюун ухаан нэвтрүүлэх асуудал ингээд манай салбар дээр зангидагдаж явах асуудал байгаа учраас магадгүй Байнгын хорооны шийдвэр гарахаар Цахим хөгжил яаманд даалгасан байдлаар шийдвэр гаргачих юм бол бусад яамныхаа хоорондын холбоо, салбар дундын зохицуулалтыг хийгээд явах ийм бүрэн боломжтой байгаа. Ойрын үедээ

хэрэгжүүлэхээр операторууд болоод Зохицуулах хороо маань бид санал нэгтгэйгээр хамтарч ажиллаж байгаа энэ дээр.

**Ж.Золжаргал:** Саяын Алтан-Од даргын хэлдэг санааг түрүүн Цэнгүүн гишүүн хэлсэн. Тэгэхээр энэ дээр бид анхаарч ажиллана. Түрүүн Лувсан-Очир даргын асуулт дээр, хариулт дээр нэг юм тодруулж асуумаар байна. Тэр шүүхийн маргаан ямар субъектүүдийн хооронд явагдаж байгаа бол? Тэгээд та түрүүн Дээд шүүх дээр очиж эцэслэгдэнэ гэсэн үү? Ямар нэгэн ийм цаг хугацааны баримжаа байгаа юу? Хэзээ шийдэгдэх бол? 3 номерын микрофон нээж өгнө үү.

**А.Лувсан-Очир:** Шүүхийн маргаан нэхэмжлэгчээр Айсинэт ХХК, хариуцагчаар Харилцаа холбооны зохицуулах хороо. 3700-аас 3800 мегагерцийн радио давтамжийн зурвасыг радио хэрэглээний үйлчилгээнд ашиглах гэдэг тусгай зөвшөөрөлтэй холбоотойгоор захиргааны хэргийн анхан шат болон давж заалдах шатын шүүхийн шийдвэрүүд нь гарсан. Анхан шатын шүүхийн шийдвэр бол үйлчилгээ эрхлэгч буюу тусгай зөвшөөрөл эзэмшигч талдаа, давж заалдах шатын шүүхийн шийдвэр эцсийн байдлаар буюу албажиж ХХЗХ-н дээр ирээгүй байна. Зүгээр шүүх хуралдаанд оролцсон мэдээллээс авахад анхан шатын шүүхийн шийдвэрийг хүчингүй болголоо гэж ойлгосон. Тэгэхээр өөрөөр хэлбэл Харилцаа холбооны зохицуулах хорооны талд шийдвэр гарсан байна гэдэг одоогоор шүүх хуралдааны явцын мэдээлэлтэй байна. Мэдээж нөгөө тал нь бол хяналтын шатаар Дээд шүүхэд давж заалдах байх. Тэр хугацааг бид нөгөө шүүхийн хараат бус байдал, хуульд нөгөө процессын хуульдаа заасны дагуу хугацаандаа тэр нь хэлэлцэгдээд явах байх. Яг хугацааг бид тэд эд гэж шүүхийн хараат бус байдал руу халдаж хэлж чадахгүй нэг.

2 дугаарт хугацааны хувьд уг Айсинэт ХХК дээр олгогдчихсон байгаад байгаа тусгай зөвшөөрлийн хугацаа нь энэ 2025 оны 1 дүгээр сарын 24-ний өдөр дуусгавар болох ийм харилцаатай байгаа. Ийм хоёр, нэг нь шүүхийн маргаан, нөгөөдөх нь тусгай зөвшөөрлийн хугацаа дуусаж байгаа ийм харилцаа байгаа.

**Ж.Золжаргал:** Энэ талаар та бичгээр мэдээлэл Байнгын хороон дээр Байнгын хорооны дарга Золжаргал гэж хаяглаад ирүүлж өгнө үү гэж хүсье. 2 номер дээр нэмэлт мэдээлэл өгөх гээд байх шиг байна, 2 номерыг нээж өгнө үү.

**У.Тамир:** Бид нарын хувьд хувийн хэвшлийн компаниудын хувьд гол нэг хүсэх юм сая Харилцаа холбооны тухай хуулийн өөрчлөлт ярилаа. Тэгээд манай салбар өөрөө ингээд бүрэн либералчлагдсан. Өөрийнхөө салбарын зохицуулалтын хүрээнд ингээд өдийг болтол явж ирсэн. Хууль, эрх зүйн хувьд ер нь харьцангуй тогтвортой байдаг. Манай Харилцаа холбооны тухай хууль бол бараг салбарын анхдагч хуулиудын нэг болж 1995 онд батлагдаж байсан. Тэрнээсээ хойш 2001 онд, тэгээд сүүлд 2019 онд нэлээн цахим шилжилттэй холбоотой дорвитой өөрчлөлтүүд орсон байгаа.

Тэрнээс хойш дахиад ингээд сүүлийн үед ер нь жоохон хуулийг оролдох, юм л бол хуулиа өөрчилж гэдэг нэг ийм юм яваад байгаа. 21 онд, одоогийн байдлаар 24 онд нэмэлт, өөрчлөлтүүд орчихсон. Тэгэхээр бид хувийн хэвшлийн хувьд юу гэж, ямар хүсэлт Их Хурлын гишүүд байгаа дээр хэлэх вэ гэвэл манай салбар шиг ингээд бүрэн либералчлагдсан ийм салбарт төрийн оролцоо байхгүйгээр явж ирснээрээ энэ салбар ийм хөгжлийн түвшинд хүрсэн гэж маш олон хүмүүс ярьж байхыг та бүхэн сонссон байх. Тэгэхээр хэт их хуулийг хурдан, хурдан хугацаанд битгий ингэж өөрчлөөд байгаасай, илүү бид нарын хууль, эрх зүйн орчин тогтвортой байгаасай.



Зохицуулах хорооны зохицуулалтынхаа хүрээнд хамрагдаад явж байгаа тохиолдолд ийм юмыг бид хүсэж байгаагаасаа илэрхийлэхийг хүссэн юм.

Түрүүн Ундрам гишүүний тэр асуусан нэг юман дээр нэмэлт нэг юм хэлчихвэл яагаад яг тэр дугаартайгаа шилжих үйлчилгээгээр нэвтрэх боломжгүй байсан юм бэ гэдэг юман дээр судалгааны дүнгүүдээс ингээд эргээд харахаар түрүүний гол ярьдаг нөгөө хэчнээн хэрэглэгч тэр үйлчилгээг авч, дугаартайгаа шилжих вэ гэдэг тоо аягүй чухал. Тэр тоо чинь өөрөө ингээд боломжийн байж бид нарын оруулж байгаа хөрөнгө оруулалтыг нөхөх ёстой. Гэтэл тэр тоо чинь өөрөө хөрөнгө оруулалтыг нөхөх хугацааг бүүр улам уртасгаад ямар ч үр ашиггүй болбол энийг ерөөсөө хэрэгжүүлэх ийм боломжгүй байдаг. Бусад улс орон ч гэсэн яг энэ үндэслэлээ хардаг учраас манайх нөгөө цөөхөн хэрэглэгчтэй, бусад нөгөө нэг олон хэрэглэгчтэй улс орнуудтай харьцуулж үзэж боломгүй байдал үүссэн учраас энэ бол хэрэгжих боломжгүй болсон гээд тэр хуулийн үр дагаврын хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ дээрээс ч гэсэн харж байсан. Тэрийг нэмж хэлэх гэсэн юм. Баярлалаа.

**Ж.Золжаргал:** Би нэг техникийн чанартай асуулт асууя. Энэ олон улсад Монголчууд зочлохдоо роуминг хэрэглэдэг. Гадаадын иргэд Монголд ирээд роуминг хэрэглэдэг. Тэгэхээр тиймэрхүү схемээр, бүүр тэр тоног төхөөрөмж, тэр юуг нь ашиглаад их өндөр үнэтэйгээр ч хамаагүй хөдөө явж байгаа хүн гэртэйгээ яаралтай холбогдохоор бол роуминг хэрэглэж болох уу? Ийм нэг асуулт байна техникийн. Ер нь яавал нэмэлт хөрөнгө оруулалт хамгийн багатайгаар, нэмэлт хөрөнгө оруулалт, техникийн өөрчлөлт хамгийн багатайгаар энэ дотоодын роумингийг хийх боломж байж болох вэ? 1 дүгээр микрофон нээж өгнө үү.

**Л.Пагмасүрэн:** Сайн байцаана уу, бүгдэд нь энэ өдрийн мэндийг хүргэе. Юнител компани Пагмасүрэн. Яах вэ нэг хэд хэдэн нөгөө юу гэдэг юм техникийн болоод бодит байдлын нэг хэд хэдэн шалтгааныг дурдах шаардлагатай юм шиг санагдаад байна л даа. 1 дүгээрт нь энэ хуулийн өөрчлөлт орох үед 2014 он байсан. 2014 онд бид ямар утастай байсан бэ гэхээр нэг төрлийн сим ордог, тэр нь хоорондоо өөр сим давтан ашиглаж болдоггүй.../үг тасрав/

**Ж.Золжаргал:** Уучлаарай 5 дугаар тогтоол шүү.

**Л.Пагмасүрэн:** Тийм, тийм 5 дугаар тогтоолын хувьд тийм. Тэгэхдээ нөгөө хэрэгжүүлэх гээд байгаа цаг үе нь, гадаад улсад яадаг вэ гэхээр өөр улс орны хэрэглэгч тэр дугааруудыг нь шууд худалдаад авах боломжгүй юм уу, аль эсхүл ийм нөгөө нэг хил хооронд, тэгээд түр зуур хэрэглэх 5 хоног, 3 хоног ийм учраас роумингийг ашиглах нь ашигтай байгаад байдаг. Өөрөөр хэлбэл урт хугацаанд ашиглах боломжгүй. Гэтэл өнөөдөр Монгол Улсад байгаа бодит нөхцөл байдал өнөөдөр Монгол Улсын нийт иргэдийн бараг хэдэн хувь нь юм 2-оос дээш симтэй утас хэрэглэж болж байгаа. Нэг дугаараа хэрэглээд, өөр дугаарын сим аваад, тэрийгээ асааж унтраагаад switch хийх боломж нь бүрэн байгаа. Тэр нь юу гэдэг юм нэг сим ойролцоогоор нэг дугаар худалдаж авахад 5 мянгаас 10 мянган төгрөгийн үнэтэй дугаарууд ч байгаа 1 сарын хэрэглээ нь. Гэтэл ийм боломжууд технологийн хувьд бодитой байхад өнөөдөр компани болгоныг 20 сая, магадгүй 50 сая ам.долларын хөрөнгө оруулаад, зүгээр түр зуур ашигладаг боломжийг нээгээч гэж байгаа нь өөрөө зүгээр ер нь бодитой юу, үгүй юү дээр нөгөө нэг төр засгийн маань зүгээс, бодлого хэрэгжүүлэгч нарын зүгээс эргээд хараасай.

Хэрэглэгч өөрөө тэр сонголтоо хийх боломж нь бүрэн нээлттэй байгаа зүйл дээр заавал хөрөнгө оруулалт хийгээд, заавал тэр хүн нэг дугаараа л бариад ингээд явж байх ёстой юм шиг ийм зохицуулалт руу орох нь өөрөө зүгээр практикал бодит хэрэглээ талаасаа хэр юм бол. Түүн дээр нөгөө бодлого зохицуулагч нар маань нэг нэмэлтээр өөр олон option энэ 14 оны зохицуулалтаас хойш гарсан шүү. Тэрийг одоо 24 онд сая 24 оны тогтоолоор дахиж заавал зөвхөн тэр зам руу явуулна гээд байгаагаас өөрөөр маш олон боломжууд зүгээр бодит байдал дээр гарсан байгаа шүү гэж операторын төлөөллийн хувьд саналаа илэрхийлье. Баярлалаа.

**Ж.Золжаргал:** Саяын миний асуулт дээр хариулах хүн байна уу? 2 дугаар микрофон.

**У.Тамир:** Түрүүн бид ярьсан энэ national роуминг ороход шилжих тэр багахан хэрэглэгчийн төлөө нэлээн их хэмжээний хөрөнгө оруулалт оруулах нь гээд. Тэгэхээр бид нарын хувьд хувийн хэвшлийнхний хувьд мэдээж хөрөнгө оруулалтын сонголтоо хийхийн тулд ямар нэгэн priority тавьж байгаа шүү дээ. Тэгэхээр яг энэ үед 5G-г нэвтрүүлэх гэж байгаа маш өндөр хөрөнгө оруулалт бид нарт хэрэгтэй байгаа, 5G-ийн бодлого нь гарчихсан, дэлхийн чиг хандлага энэ рүү бид явахаас өөр аргагүй болчихсон нөхцөлд тэрийг сонгох уу, энийг сонгох уу гэдэг асуудал чинь өөрөө 5G-н хөрөнгө оруулалтыг удаашруулах юм руу аваачихгүй байх нь зүйтэй юм. Яагаад гэвэл үр ашгийг ч гэсэн тэнцүүлж харьцуулж үзэхэд бол энэ нь илүү юм гэж.../үг тасрав/

**Ж.Золжаргал:** Үгүй ээ би танаас техникийн боломж байна уу гэж асуугаад байна шүү дээ. Гадаадад хэрэглэж байгаа роумингийн тэр схемийг ашиглаад эсхүл өөр ямар нэгэн хямдхан аргаар хийх боломж байна уу, үгүй юү? Техник талаасаа 1 номерын микрофон нээж өгье.

**Ш.Батзаяат:** Техник талаас нь Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Бодлогын газрын дарга Батзаяат байна. Таны асуултад хариулахад техник бол манай операторууд роуминг үйлчилгээнд хамрагдахдаа бол гаднын роуминг оператораар дамжиж холболтууд хийгдэж байгаа. Тэгэхээр өөрөөр хэлбэл бид хэд дотоод роумингээ хийх юм бол ямар нэгэн байдлаар роуминг provider-оор бол дамжих хэрэг гарч байгаа. Тэгэхээр түрүүн ярьж байсан манай операторуудын дийлэнх нь ярьж байгаа хөрөнгө оруулалт гээд байгаа зүйл нь энэ харилцан холболтуудыг хийх, роумингийн үйлчилгээ үзүүлэх оператор дээр гарах хөрөнгө оруулалтын тухай ихэнх нь ярьж байх шиг байна.

Роуминг хийе гэх юм бол 2 зохицуулалт, 2 боломжоор техник талын хийж болж байгаа. Нэг нь гадагшаа гарч байгаа буюу одоо хийгдэж байгаа роуминг оператораараа дамжих буюу доторх хийгдэж байгаа дуудлагууд маань гадна роуминг оператораараа зохицуулагдаж явагдах нэг арга хэмжээ. Нөгөөдөх нь Монгол Улс дотроо роумингийнх нь provider-ийнх нь үйлчилгээ хийх гэсэн ийм 2 янз байгаа. Тэгэхээр түрүүн их хөрөнгө оруулалт хэрэгтэй гээд байгааг нь би ойлгохдоо энэ дотоод роумингээ зохицуулахад хийх дээр хөрөнгө оруулалт хэрэгтэй, тэрний тухай яригдаад байх шиг байна. Тэр нь бол нэлээдгүй хөрөнгө оруулалт шаардагдах ийм хүчин зүйлстэй байгаа.

**Ж.Золжаргал:** Баярлалаа. Хэлэлцэж байгаа асуудалтай холбоотой үг хэлэх үү гишүүд? Үг хэлэх гишүүн байхгүй. 6 номерын микрофон нээж өгнө үү. Тулгат зөвлөх.

**М.Тулгат:** Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын зөвлөх Тулгат. Цэнгүүн гишүүний асуулт дээр нэмэлтээр мэдээлэл өгье. 1 дүгээрт 111, 112 дугаартай холбоотой гаргасан санал санаачилгыг дэмжиж байна. Учир нь энэ зөвхөн техникийн асуудал биш, цаана нь Эрүүл мэндийн яам, Хууль зүйн яам, онцгой байдал гэх мэт ийм салбарын яам, байгууллагуудын зохион байгуулалтын асуудал яригддаг учраас үүн дээр цаашид манай яамны зүгээс холбоод, ингээд энэ асуудлын зохицуулалтыг нь хийгээд явъя гэсэн ийм байр суурьтай байгаа. Мөн тус яамны зүгээс ийм байдлаар ажиллаж байгаа гэдэг мэдээллийг өгье 1 дүгээрт.

2 дугаарт Харилцаа холбооны тухай хуулийн тухайд сая хувийн хэвшлийн төлөөллийн зүгээс энэ хууль их байн, байн ингэж өөрчлөгдөх нь бидний ажилд хүндрэл учруулна гэж хэлж байна. Энэ дээр бол санаа зовох зүйл байхгүй. Учир нь энэ удаагийн өөрчлөлтийн гол зүйл юу вэ гэхээр төрийн байгууллага хоорондын уялдааны асуудал байгаа. Яам болон Зохицуулах хороо, жишээлбэл улсын байцаагч гээд 2, яаман дээр байдаг, зохицуулах хороон дээр байдаг, аль нь хийх юм бэ гэдэг шиг иймэрхүү асуудлууд байгаа. Мөн нэр томъёоны асуудал гэдэг ч юм уу цэгцлэх ийм асуудлууд байгаа.

Мэдээж энэ хуультай холбоотой эрх ашиг нь хөндөгдөх бүх талуудтай ажлын хэсэг бол цаашид саналуудыг нь тусгаад явна. Нэг номерт бид хувийн хэвшилдээ ямар нэгэн илүү төвөг чирэгдэл учруулахгүй гэдэг энэ байр суурь дээр явна. Энэ хууль маань анх 1995 онд батлагдаад, 2001 онд шинэчилсэн найруулга хийгдсэн ийм хууль. Өнөөдөр маш олон нэмэлт, өөрчлөлт гээд орчихсон, харахад их төвөгтэй бүүр ийм болчихсон байгаа хууль. Тэгэхээр энэ 2001 оноос хойш өнөөдрийг хүрэхэд энэ 2024 оны энэ өндөрлөгт хүрэхэд энэ салбар маань өөрөө асар их өөрчлөгдчихсөн, үсрэнгүй ийм хөгжлийн технологийн өөрчлөлт дунд байгаа ийм цаг үед ер нь бол зөвхөн нэмэлт, өөрчлөлт биш, энэ бол бараг шинэчилсэн найруулгын хэмжээнд яригдах ийм зүйл байгаа гэсэн ийм зүйлийг хэлмээр байна. Баярлалаа.

**Ж.Золжаргал:** Хуулийн нэмэлт, өөрчлөлтийн талаар тодорхой тайлбарыг өглөө. Та бүхэндээ баярлалаа. Дүгнэлт болгоод хэлье гэж бодож байна. 1 дүгээрт нь энэ төрийн бодлого Улсын Их Хурлаас гарч байгаа шийдвэр бол нэлээн олон хүмүүсийн үгэнд дурдагдаад байх шиг байна. Тийм муйхар, тулгасан байдлаар явахгүй. Тийм болохоор энэ салбарын хүмүүсийг сонсож, өнөөдөр энэ мэдээллийг авч байгаа юм. Төрийн байгууллагуудаас гадна зориуд операторууд хувийн хэвшлийнхнийг урьж оролцуулсан. Энэ Инновац, цахим бодлогын байнгын хорооны гишүүд мэдээллийн технологийн чиглэлээр, зарим нь харилцаа холбооны чиглэлээр ойлголттой, туршлагатай ийм хүмүүс байгаа. Улсын Их Хурал дээр гарах шийдвэрүүд бол нэг хэдэн дарга нарын төсөөллөөр гардаг байж болохгүй. Ажлаа хийж байгаа, асуудлаа мэддэг, яг амьдралдаа орооцолдоод явж байгаа хүмүүстэй ярилцаж байж гарна.

Нөгөө талдаа Их Хурлын хууль тогтоох байгууллагын гаргаж байгаа шийдвэр хэрэглэгч, олон талын эрх ашгийг дэнсэлж үзэх ёстой, тийм биз. Тийм болохоор бид хэрэглэгч талаасаа ийм эрэлт, хэрэгцээ байгаад байна гэдэг мессежийг их авч байгаа. Тэгээд гаргасан тогтоолын хэрэгжилт ямар байна вэ гэж өнөөдрийн энэ хэлэлцүүлгийг сонсголыг зохион байгуулж байгаа юм.

Байнгын хорооны чиг үүрэгт энэ хуулийн хэрэгжилтийг хянах тийм даалгавар байгаа, гол чиг үүргийнх нь нэг. Тийм болохоор бид хуулийн хэрэгжилтийг хангуулах үүрэгтэй. Энэ хуулийн хэрэгжилт, энэ Улсын Их Хурлын тогтоол бол Монгол Улсын Засгийн газар /Ерөнхий сайд Оюун-Эрдэнэ/-т даалгасугай гээд тогтоочихсон.

Тэгэхээр энэ 5 дугаар заалтыг бид мухарлах ёстой. Үүний хүрээнд Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам, Алтан-Од дарга энд байгаа. Алтан-Од дарга, тэгээд Харилцаа холбооны зохицуулах хороо Чинзориг дарга та бүхнийг онцгой анхаарал хандуулаад, энэ дээр хариуг нь албан ёсоор бичгээр буулгаж ирүүлээрэй гэж хэлмээр байна.

Тогтоол гарсан. Тийм болохоор би ийм зүйлийг бүр зориуд цохон тэмдэглэмээр байна. Мэдээж хүндрэлтэй юмнууд байгаа. Ямар ч ажил хийхэд үр ашигтай юм уу, утгатай юм уу, үгүй юм уу гэдэг асуулт гарч ирнэ. Тэгэхдээ хууль тогтоох байгууллага бол өгөгдөл гаргаж байгаа. Монгол Улсын иргэдээс сонгогдсон хүмүүс цуглаж сууж байгаад та бүхний ажиллах орчныг бий болгож байгаа, энэ бол өгөгдөл байхгүй юу. Тэгэхээр энэ өгөгдөл чинь дотоодын роумингийг хий гээд өгөгдөл гаргачихсан байна. Тэгэхээр яавал хийхэд боломжгүй байна вэ гэж биш, ямар арга барилаар, хамгийн бага хөрөнгө оруулалттай, хамгийн богино хугацаанд энэ дотоодын роумингийг хийж болох вэ гэдэг шийдлийг та бүхэн боловсруулаад танилцуулаач. Түүний дараа хийх үү, үгүй юу гэдэг асуудлыг тусад нь ярья. Тэгж байж бид Байнгын хороон дээр дахиж шийдвэр гаргах, тогтоол гаргах ийм түвшний хурлыг бол хийнэ гэж бодож байна.

Тэгээд 112 дугаар онцгой тохиолдолд яаралтай холбоо барих энэ асуудлыг аль болохоор түргэн шийдчихье. Энэ шаардлагатай Байнгын хороон дээр гарах шийдвэр байх юм бол бид идэвхтэй ажиллахад бэлэн байна. Тэгээд дахин хэлэхэд хууль тогтоох байгууллага өөрөө дураараа юм зохиож гаргана гэж байхгүй. Энэ салбар дээр ажиллаж байгаа та бүхэнтэй нягт хамтарч ажиллаж, сонсож, ойлгож байж гаргана. Гэхдээ гаргаж байгаа шийдвэр бол энэ салбарт ажиллаж байгаа байгууллагын эрх ашигт нийцсэн байх, түүнээс гадна хамгийн гол нь нийт Монголчуудын эрх ашигт нийцсэн байх ийм байх ёстой шүү дээ. Тийм болохоор нээлттэй, илэн далангүй ямар боломжууд байна тэрийг ийм ажил хэрэгч байдлаар гаргаж тавиарай л гэж хүсмээр байна. Гишүүд үг хэлж дууссан.

14.03 цаг

Байнгын хорооны өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан өндөрлөснийг мэдэгдье. Та бүхэндээ баярлалаа.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,  
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА